

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр, Лхгава гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-49

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/ 6-7

2.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэх 7-25

3.Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлт, тайланг хэлэлцэх 25-38

4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/ 38-49

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
03 дугаар сарын 26-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 11 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир, Ж.Галбадрах;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, М.Сарнай.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Ч.Ундрам тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ч.Ундрам: “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн

дарга Х.Батжаргал, мөн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Б.Энхбаяр, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Асуултын хариуг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулав.

Асуултын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ц.Мөнхтуяа, Ш.Бямбасүрэн, О.Саранчулуун, Т.Аубакир, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусае.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням 16 цаг 16 минутаас 17 цаг 31 минутад хуралдааныг удирдав.

Гурав.Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлт, тайланг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Б.Энхбаяр, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо ажлын албаны референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Д.Рэгдэл, Б.Хэрлэн, Г.Дамдинням нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Уг асуудлыг 16 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Б.Энхбаяр, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо ажлын албаны референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, О.Саранчулуун, С.Эрдэнэбат, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Дамдинням: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Тогтоолын төслийн 1.9 дээр дэлхийн шилдэг их сургуулиудын сургалтын төлбөрийн тодорхой хувийг гадаад, дотоодын бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн суралцагчийн үлдсэн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгах гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 11 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Хэл засалч, хөдөлгөөн засалч, протезын техникч, хөдөлмөр засалч зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажилладаг Монгол Улсад нэн дутагдалтай байгаа мэргэжилтнүүдийг бэлтгэхэд дэмжиж, төгсөөд мэргэжлээрээ боловсролын байгууллагаас гадна сургалтын эмнэлэг, сувилал, сэргээн засах төв зэрэг газар ажиллуулах зорилгоор 2 дахь удаагаа суралцагчийг дэмжиж болно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов

Нийт 11 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын гаргасан, Төслийн 1.14-т Малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны 1 хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах журмыг боловсруулах гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан санал болон ажлын хэсгийн хэлэлцүүлгийн үед гарсан саналуудыг тусгах, найруулга зүйн хувьд ажиллаж, эцэслэх байдлаар тогтоолын төслийг бүхэлд нь дэмжиж баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

Уг асуудлыг 17 цаг 31 минутад хэлэлцэж дуусаав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, ирвэл зохих 15 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн *ирцтэйгээр* 17 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 26-ний өдөр,
Лхаав гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 11 минут.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Ундрэм: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ирвэл зохих 15 гишүүнээс 9 гишүүн ирж, ирц 60 хувьд хүрсэн учраас хуралдаанаа эхлүүлье. Ирцийг дэгийн дагуу танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай ирсэн. Отгоншарын Батнайрамдал ирсэн байна. Дуламын Бум-Очир чөлөөтэй, Шинэбаярын Бямбасүрэн ирсэн байна. Жанчивын Галбадрах чөлөөтэй, Амгаланбаатарын Ганбаатар чөлөөтэй, Гонгорын Дамдинням ирсэн байна. Цэндсүрэнгийн Мөнхтуяа ирсэн. Дүгэрийн Рэгдэл ирсэн. Отгоны Саранчулуун ирсэн. Мягмардашийн Сарнай чөлөөтэй, Чинбатын Ундрэм ирсэн. Ганбатын Хосбаяр арай ирээгүй байна. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирчихлээ. Ингээд 10 гишүүнтэй, ирц 66.7 хувьтай болсон байна. Өнөөдрийн хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Нэгт, Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай” ийм төсөл байна.

Хоёрт, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдалаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцүүлнэ.

Гуравт нь Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлт, тайланг хэлэлцэнэ.

Дөрөвт, Байнгын хорооны тогтоолын төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” энэ тогтоолын төсөл. Энэ 3 дугаар асуудал дээр хэлэлцэж байгаа энэ ажлын хэсгийн ажилласны үр дүнгээр ийм тогтоолын төсөл гарч байгаа. Энийг хэлэлцэнэ. Ийм 4 асуудал байна.

Энэ хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэгдүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нэмэлт оруулах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг үндэслэн тогтоох нь:

1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Г.Хосбаяр нарыг нэмсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Энэ ажлын хэсэг маань орчин үеийн ариун цэврийн байгууламжийн ажлын хэсэг байгаа. Тэр дээр энэ 2 гишүүн маань саналаараа оръё гэсэн. Тэгээд Дэгийн тухай хуулиараа заавал Байнгын хороон дээр санал хураалт болж байж ордог ийм байна.

Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт хийнэ. Энэ дээр та бүхнээс асуух асуулт, хэлэх үгтэй гэх гишүүн байна уу?

Байхгүй.

Ариун цэврийн байгууламжийн ажлын хэсэг байгаа. Тэгвэл саяын миний хэлсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалтаар 10 гишүүнээс 8 гишүүн зөвшөөрч, 80 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

15.15 цаг

Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдалаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг Боловсролын сайд Наранбаяр танилцуулна.

Мөн асуулт хариултад Наранбаяр сайдаас гадна Боловсролын яамнаас энэ, эд нар ирсэн тогтоол дээр юм уу, дүгнэлт дээр нь юм уу? Энэ тэгнэ танилцуулга хийгдсэний дараа асуултаа асууна.

Боловсролын сайд Наранбаяр, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын яамны Гадаад, хамтын ажиллагааны газрын дарга Б.Энхбаяр, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал нар ирсэн байна.

Ингээд Наранбаяр сайд танилцуулгаа хийе.

П.Наранбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдалаас ирүүлсэн асуултын хариуг та бүхэнд танилцуулъя.

1 дүгээр асуултын тухайд,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан илгээлт 2100 хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилийн сонгон шалгаруулалттай холбоотой өргөдөл, гомдлыг судлан үзэхэд Боловсролын яаманд давхардсан тоогоор 15 өргөдөл ирсэн байна. Эдгээр өргөдлийг үзэхэд Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын 1.9 буюу өрхийн 1 гишүүн хамран сургах тойргийн асуудлыг түгээмэл хөнджээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолд тодорхой тусгаж өгсөн Боловсролын яамны харьяа Боловсролын үнэлгээний төв, Боловсролын ерөнхий газар, Боловсролын зээлийн сан, Боловсролын мэдээллийн төв гэсэн байгууллагуудын системээр дамжуулан мэдээллийг солилцож, тухайн баазад суурилан сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг.

Багш, ажилтны хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлгийн асуудлаар Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолын 2.3.6 дахь заалтад заасан тасралтгүй 15 жил ажилласан байх заалттай холбоотой гомдол түгээмэл байна.

Боловсролын зээлийн сангаар олгож буй гадаадад суралцагчдын зээл, тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг цахимжуулах ажлыг журмын шинэ шинэчлэлд тусган хэрэгжүүлнэ.

Асуулт хоёрдугаархын тухайд,

Боловсролын зээлийн сангийн зээлийн эргэн төлөлт 2024 оны нийт 2024 онд нийт 14.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 15 хувиар өссөн. Зээлийн эргэн төлөлтийг хөтөлбөр тус бүрээр нь авч үзвэл хөнгөлөлттэй зээл 363.18 сая төгрөг буюу өнгөрсөн оноос 52 хувь, оюутны хөгжлийн зээл 11.5 сая төгрөг буюу өнгөрсөн оноос 46 хувиар тус тус өссөн бол гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын зээл 2.4 тэрбум төгрөг төлөгдөж, өнгөрсөн оноос 40 хувиар, 43 хувиар буурсан.

Зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор 2024 оны 11 дүгээр сараас эхлэн оюутны хөгжлийн зээл, хөнгөлөлттэй зээл болон дэлхийн шилдэг их, дээд сургуульд зээлээр суралцсан иргэдэд зориулан E-Mongolia цахим системээр дамжуулан зээлийн мэдээлэл хүргэх үйлчилгээг нэвтрүүлээд байна.

Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад хөнгөлөлттэй зээлийг 1992-2016 онд олгосон бөгөөд Засгийн газрын 2004 оны 22 дугаар тогтоолоор 1992-2004 оны суралцагчдын зээлийг бүрэн чөлөөлсөн. Засгийн газрын 2008 оны 178 дугаар тогтоолоор голч дүн 2.8, эзэмшсэн мэргэжлээрээ 2 болон түүнээс дээш жил ажилласан шалгуурыг хангасан төгсөгчдийг зээлээс чөлөөлж байна.

Одоогоор Боловсролын зээлийн санд 2004-2016 онд хөнгөлөлттэй зээлээр суралцаж төгссөн нийт 12799 зээлдэгчдийн 14.1 тэрбум төгрөгийн зээл бүртгэлтэй байна.

Уг зээлийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх талаар албан бичигт Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах, гэрээ хийгдсэн огнооноос үл хамааран нөхөж илгээх

боломжтой талаар магадлал, мэдээлэл ирүүлсний дагуу Зээлийн мэдээллийн санд хүргүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн.

Зээлийн эргэн төлөлтийг сайжруулах хүрээнд 7 аймаг, 2 дүүргийн прокурорын байгууллагуудтай хамтран ажиллаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Оюутны хөгжлийн зээл нь 2016 оноос эхэлсэн бөгөөд зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор E-Mongolia цахим системээр дамжуулан зээлийн эргэн төлөлтийн графикийг 2025 оны 2 дугаар сараас эхлэн зээлдэгчдэд хүргэх бэлтгэл ажил хангагдаад байна. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагыг 1997 оноос хойш суралцаж төгссөн бүх төгсөгчдийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийг үүсгэж Монголбанк руу зээлдэгчийн зээлийн мэдээллийг нийлүүлэх бэлтгэл ажил хангагдаж байна.

Дэлхийн шилдэг их сургуульд суралцсан 2010-аас 20 онд иргэдийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор E-Mongolia цахим системээр дамжуулан зээлийн мэдээллийг 2024 оны 11 дүгээр сараас эхлэн хүргэж мэдээллээр ханган ажиллаж байна.

Зээлийн сангийн хуримтлагдсан авлагыг барагдуулах чиглэлээр олон улсын сайн туршлага судлах, хамтран ажиллах, хуулийн фермийг сонгон шалгаруулах зэрэг ажлыг төлөвлөж байна.

3 дугаар асуултын тухайд,

Оюутны хөгжлийн зээлийн мэдээллийг тусгай программ дээр боловсруулж Монголбанк руу нийлүүлж байгаа боловч гадаад зээлдэгчдийн мэдээллийг уг программд бүртгүүлэх тохируулга хийгдээгүй, мэдээлэл солилцох боломжгүй байна. Оюутны хөгжлийн зээлийн программыг ашиглан гадаад зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг боловсруулах, нийлүүлэх үйл явцад системийн хүчин чадал дутмаг байна.

Одоогийн ашиглаж буй 2018 оны программ хангамж болон өгөгдлийн сан нь техникийн болон үйл ажиллагааны шаардлагыг хангаж чадахгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Гадаад зээлдэгчдийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Улсын бүртгэлийн газраас регистрийн дугаарын солилцоо болон авлагын мэдээллийг тулгах ажлыг зээлдэгч тус бүрээр хийж эхэлсэн.

Боловсролын зээлийн сангийн мэдээллийн системийн архитектурыг боловсруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлын хэсэг гарсан Боловсролын сайдын 2025 оны хөтөлбөр, арга хэмжээний зардлын төсөвт сангийн цахим шилжилттэй холбоотой зардлыг санхүүжүүлэхээр тус тус тусгасан болно.

4 дүгээр асуултын тухайд,

Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх 13 арга хэмжээнд нийт 158.4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 124.4 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор байна.

Уг санхүүжилтийг хэрхэн бүрдүүлэх талаар гэрээний биелэлтийг дүгнэх, биелэлтэд хяналт тавих, гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан өр, авлагыг барагдуулах зорилгоор хуулийн фермтэй хамтран ажиллана.

Мөн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах хүрээнд хууль, шүүхийн байгууллагад хандах, өмнөх онуудад үүссэн зээл чөлөөлөлтийн асуудлыг тодорхой болгон эргэн төлүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн 2025 онд нийт 30 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг төлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

5 дугаар асуултын тухайд,

Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын 4.13 дахь заалтад гадаадын сургалтын байгууллагад магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах төрийн албан хаагчдаас холбогдох шаардлагыг хангасан тохиолдолд тухайн байгууллага нь шалгаруулж Боловсролын сайдын тушаалаар баталгаажуулан Боловсролын зээлийн сантай 3 талт гэрээ байгуулна.

Төрийн албан хаагчдад олгох зээл тэтгэлэг нь 2025 оноос эхлэн хэрэгжих бөгөөд тус хөтөлбөрт 50 суралцагчид 3.5 тэрбум төгрөгийг 1 суралцагчдад дунджаар сургалтын төлбөр 20 мянган ам.доллар зарцуулахаар төлөвлөж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага гадаад сургалтын байгууллагад суралцуулах суралцагчийн тоо, боловсролын зэргийн хөтөлбөр, мэргэжлийн чиглэл, санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллийг Сан жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор ирүүлэхээр тогтоолд заасан.

6 дугаар асуултын тухайд,

Багшийн мэргэжлээр суралцагчдыг дэмжих хүрээнд 2024 онд 4728 суралцагчид 9.6 тэрбум төгрөг, багш, ажилтны хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт 2 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон.

Дотоодын сургалтын байгууллагад эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр суралцагчдыг дэмжих зорилгоор 5208 суралцагчид 10.6 тэрбум буюу төгрөгийн зээл, тэтгэлэг олгосон.

Элсэлтийн шалгалтыг 2024-25 оны хичээлийн жилээс эхлэн жилд 2 удаа зохион байгуулж, 2025-аас 26 оны хичээлийн жилд босго оноог 490, орон нутгийн сургуулийн босго оноог 430 болгож тус тус 10 оноогоор нэмэгдүүлэв.

Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч ажиллангаа сурах, суралцангаа ажиллах боломжийг бүрдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

7 дугаар асуултын тухайд,

Хөдөлгөөн засалч, хэл засалч мэргэжлээр суралцагчдын хувьд санхүүжилт нээлттэй байгаа хэдий ч тэтгэлэгт хамрагдах хүсэлт ирээгүй. Нэн эрэлттэй мэргэжлийн хувьд төгсөөд орон нутагт 3 жил, нийслэлд 5 жил ажиллах нөхцөлийг зөвшөөрөхгүй тохиолдол гарч байгаагаас эрэлттэй мэргэжлийн суралцагчид

тэтгэлэгт хамрагдах нь бага байгаа тул санхүүгийн дэмжлэгийн нөхцөлийг өөрчлөн сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Сургалтын төлбөрийн дотоодын зээлийг эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн мэргэжил харгалзахгүй болгох тэтгэлгийг, нөхцөлийг гэрээний үүрэгтэй холбох Боловсролын зээлийн сангийн үйлчилгээг олон нийтэд таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбоотой зардал тодорхой бус байгааг журамд шинэчлэн тусгахаар судалж байна.

Баярлалаа.

Ч.Ундрам: Танилцуулаад дууслаа. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулчихсан.

Одоо мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүн байвал нэрээ өгөөрэй. Байнгын хуралдааны асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асууна гэсэн ийм дэг байгаа юм байна.

Үүний дараа асуулга тавьсан гишүүн маань 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, асуулгатай холбоотой өөр асуулт асуух гэж заасан байна.

Тэгэхээр асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуучихгүй юу даа нэрээ өгөөд.

Бямбасүрэн гишүүнээр тасалъя. Ингээд Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Багш нараас голцуу 1 хүүхдийн сургалтын төлбөрийг бас төрөөс хариуцна гээд энэ шийдвэр гарсан. Тэгээд тасралтгүй 15 жил энэ тэр гээд байгаа энэ дээр бас хоёрын хооронд 1, 2 сарын хүний амьдрал болсон хойно дунд нь асуудал байдаг. Тэрийг нь тасралтгүй гэж үзээд магадгүй тэр хүн 3 сар ч гэдэг юм уу, өвдсөн янз янзын шалтгаантай байж болно. Тэгээд энийг энэ журамдаа оруулчих яг хэрхэн хэрэглэж байгаа вэ? Журамд нь оруулаад шийдчих боломж байхгүй юу 1 дүгээрт.

Хоёрдугаарт тэр 30 тэрбум төгрөгийг Боловсролын зээлийн сангаас зээл авсан хүмүүсийг энэ жил төлүүлнэ гээд тавьчихсан. Одоо яг ямар, хэдэн хувьтай байгаа вэ? Энэ мөнгө зээл хэрвээ төлөгдөхгүй бол 30 тэрбум дээрээ төлөгдөхгүй бол тэтгэлэг авах хүүхдүүдийн хэмжээ, тоо хасагдах, эс үгүй бол энэ тэтгэлгийн хэмжээ буурах ийм эрсдэл байна уу?

Гуравдугаар асуудал нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулна гээд бэлтгэл ажил хангагдаж байгаа гэж. Энэ яг хэзээ орох юм бол?

Дөрөвдүгээрт нь ер нь энэ яг гэрээний үүргээ биелүүлчихсэн байгаа бас хүмүүс дотор нь яваад байгаа юм. Тэтгэлэг аваад, буцаж ирээд гэрээнд заагдсан төрийн албандаа ажиллаад, тогтвор суурьшилтай үр бүтээл гаргаж байгаа энэ хүмүүсийн асуудлыг ер нь цаашаа яах юм бэ? Зээлийн сангийн гэрээнийх нь үүргийн дагуу хөнгөлөөд гэрээнийх нь үүргийг дүгнээд тавихгүй бас маш олон хүмүүс хүлээгээд байгаа юм байна лээ. Тэгээд нийгмийн сүлжээгээр зээл авсан нь бараг буруу мэт ч юм уу ийм байдлаар хэт ингээд яачихсан учраас энэ хүмүүсийг

бас дунд нь хэлмэгдүүлээд байж бас болохгүй. Үнэхээр гэрээнийхээ үүргийг биелүүлчихсэн юм бол тэр хүмүүсийн гэрээг нь дүгнээд тодорхой юуг нь хаахыг нь хаагаад, харин огт гэрээнийхээ үүргийг биелүүлээгүй, Монголдоо бараг буцаж ирээгүй, төрийн байгууллагадаа ажиллаагүй ийм хүмүүсийг, эс үгүй бол сураагүй дундаас нь хаяад явчихсан энэ хүмүүсийг ялгаж салгаад шийтгэх тал дээр яг ямар арга хэмжээ авч байгаа вэ гэдгийг хэлмээр байна.

Ч.Ундрам: Хуралд Хосбаяр гишүүн ирсэн байна. Ирцэд орьё. Мөн Аубакир гишүүн оролцож байна.

Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ нарийн ширийн тоог манай Сийлэгмаагаас бас хариулж өгөхийг хүсье. Тэр хууль дээр тасралтгүй 15 жил гээд, тасралтгүй гэдэг үг нь орчхоод байгаад байгаа юм л даа. Үнэхээрийн тэр дунд нь яг амьдрал өөрөө их баян, янз бүрийн шалтгаанаар түр завсарласан хүмүүс ийм байдаг. Тэгэхээр энэ дээр бас энэ бид бас энийг аль болохоор л багш нартаа өгөхөөр ийм юутай байгаа. Ер нь зүгээр НДШ-ийг нь харж байгаад ер нь бид яг энэ 15 жил тасралтгүй ажилласан байна уу, үгүй юү гэдгийг бас ингэж харж байгаа.

Нийт 34 тэрбум байхаас 14.6 тэрбум төгрөг нь буцаан төлөгдчихсэн ийм нөхцөл байдалтай байгаа. Юуны хувьд бол. Энэ жил чинь бас төсөв бас нэлээн танагдаад энэ 33 тэрбум төгрөг буцааж өөрсдөө олж ав гэсэн ийм байдалтай байгаа. Тэр өнөөдөр тэр Монголбанк руу явуулах гэж байгаа мэдээлэл эд нар дээр бид бас энэ өнөөдрийн байдлаар 3500 орчим хүн зээл аваад ингээд эндээсээ ойролцоогоор өнөөдөр 2500 орчим нь төлөөд, суралцаад явж байгаа ийм хүмүүс, ийм харилцаанд байгаа улсууд, зээлээс чөлөөлөгдчихсэн 1000 орчим хүн байгаа. Энэ дээр үнэхээрийн өөрийн тань хэлдэг ирээд суралцсан эрдэм номоо эх орондоо зориулаад, гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээд ингээд явчхаж байгаа. Тэгээд тэр гэрээнд хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн учраас чөлөөлөгдсөн улсууд ч бий, энэ дотор хариуцлага алдсан хүмүүс ч бий. Энийг ялгаж, салгах ажил ид явж байна гэж ойлгох хэрэгтэй. Тэр тохиолдлыг нь ялгаж салгаад ингэсэн тохиолдолд бид хариуцлага хүлээлгэхээр хүн байвал хариуцлагыг нь хүлээлгэнэ гэсэн ийм юутай байгаа.

Тэгэхээр Монголбанк руу явуулах мэдээлэл эд нар үүнтэйгээ уялдаж байгаа гэдгийг хэлье. Өшөө тоонуудыг манай Сийлэгмаа бас нөхөөд хариулчих уу?

Ч.Ундрам: 8 номерын микрофоныг өгье. Сийлэгмаа.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулъя. Зээлийн сан Сийлэгмаа Зээлийн эргэн төлөлтийн хуваарь 2022 оноос хойш жил болгон 30 тэрбумаар Сангийн яамнаас төлүүлэх гэж байгаа. Жил ирэх тусам бид 4-14 тэрбум хүртэл сүүлийн 5 жил эргэн төлөлт хийгдсэн. 24 онд 30 тэрбумын төлөхөөс 14.6 тэрбум төгрөгийн төлөлт хийгдсэн байна.

15 жилийн тасралтгүй гэдэг дээр яг НДШ-ийн тодорхойлолтыг харж байгаад тасралтгүй сар тасраагүй байх энэ зохицуулалтаар багшийн 15 жилийн хүүхэд, 1 хүүхдийн тэтгэлэг олгогдож байгаа ийм тоо байна.

Ч.Ундрaм: Энэ гэрээний үүргээ гүйцэтгэчихсэн, гэрээнийхээ дагуу зээл авч сурчхад 5 жил ажиллачихсан ийм яг хэдэн хүүхэд байгаа юм? Энэ хүүхдүүдийг, хүүхэд ч яах вэ том хүмүүс байгаа эд нарыг яах юм бэ ер нь цаашид?

8 номерын микрофон Сийлэгмаа.

О.Сийлэгмаа: Гэрээний үүргийн биелэлттэй холбоотой тогтоолын хэрэгжилт нь 1997-2012 он хүртэл тогтоолоор суралцсан иргэд Засгийн газраар орвол шийдвэрлэх ёстой. Гэтэл үүнээс хойш 11 оны хуулиар Улсын Их Хурлаас журамлана гэхчхэн. Улсын Их Хурлын журам гараагүй учраас энэ гэрээний хэрэгжилтийг сайд чөлөөлөх нь өөрөө эрх зүйн зохицуулалтын зөрчилтэй байгаа учраас 24 онд чөлөөлөлт хийгдээгүй.

Одоогийн байдлаар чөлөөлөгдөөгүй 1200 иргэдээс 5 жил ажиллачихсан буюу яг 2012 он хүртэл гэрээгээр суралцсан иргэд нийтдээ 800 орчим байгаа.

Ч.Ундрaм: Улсын Их Хурал чинь журам гаргахгүй шүү дээ. Хууль л гаргана тийм ээ, эсвэл тогтоол гаргана.

Тэгэхээр яг энэ дээр энэ хуулийн хийдэл байгаад байгаа, байхгүй юу. Тэгэхээр энийгээ та хэд маш яаралтай засах хэрэгтэй байна.

Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тийм ээ, энэ яг ийм асуудал үүсээд байгаа үнэн. 2011 оны тэр хуулийн өөрчлөлтөөр Дээд боловсролын санхүүжилтийн тухай хууль гээд. Тэрнээс хойш Улсын Их Хурал журам гаргаж чөлөөлнө гэж заасан боловч тэр журам гараагүй. Тэгээд гэрээ байгуулагдаад яваад байдаг. Тэгээд гэрээнд хүлээсэн үүргээ биелүүлчихсэн ийм хүмүүсийг тэрний дараа чөлөөлсөн гэсэн ийм асуудал 864 хүн байдаг байх. 60 орчим хүн дээр үүсчхээд байж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр нэгэнт журам нь гараагүй, тэгээд энэ дээр гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн гэж үзээд тухайн тухайн үеийн бас Боловсролын сайд нар чөлөөлчихсэн энэ асуудал дээр бид бас энэ Захиргааны ерөнхий хуулийн тэр 48 дугаар зүйл дээр байдаг захиргааны актыг сөрөг нөлөө үзүүлж байгаа акт уу, эерэг нөлөө үзүүлж байгаа акт уу гэдгийг харж эндээс бас хөөн хэлэлцэх цаг хугацаатай холбоотойгоор бас шийдвэр гаргах шаардлагатай. Энийг Засгийн газраар оруулж хэлэлцүүлж шийдүүлнэ. Цаашдаа бид энэ зөвхөн хувь.

Ч.Ундрaм: Дараагийн асуулт Мөнхтуяа гишүүн асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Олон жил энэ Боловсролын зээлийн сангийн булхай луйврын асуудал хөндөгдөж, яригдаж ирсэн. Гэхдээ энэ 2 жилийн өмнө энэ Батнайрамдал гишүүн гишүүн байхаасаа өмнө энийг нийгэмд бас шүгэл үлээж гаргаж ирж, энэ асуудал руу бас идэвх санаачилгатай манлайлж орж байгаа ийм залуу гишүүн. Тэгээд Батнайрамдал гишүүндээ бас баяр хүргэмээр байна.

Сая тэр 24 онд 30 тэрбум төгрөг төлөгдөхөөс 14.6 тэрбум төгрөгийг нь төлчихсэн гээд сая Сийлэгмаа дарга мэдээлэл өгч байна. Би энийг бас асуух гэж байсан юм. Яг хэдэн төгрөг орж ирээд төлөгдчихсэн байгаа юм бэ гэдэг асуудлаар.

Хоёрдугаарт, Боловсролын сайд Наранбаяраас асуух асуулт байна. Шинэ Монгол сургуулийн төлөөлөл гэж Наранбаяр сайдыг бүгд мэднэ. Энэ Галбадрах гишүүний сургууль буюу Шинэ Монгол сургуулийн сургуулийн менежмент гэсэн ийм төсөл рүү 120 сургуулиас 10, 10 сая төгрөг буюу 1.2 тэрбум төгрөгийг шилжүүлсэн ийм баримтууд ингээд ил болоод явж байгаа нийгэмд. Ер нь багш нар, сургуулиуд энэ дээр маш их мэдээллийг надад өгч байгаа. Энэ асуудал дээр яагаад ийм болчимгүй юм хийчхэв ээ гэж би асуумаар байна Наранбаяр сайдаас. Энэ ерөөсөө цэвэр авлига, ашиг сонирхлын зөрчил шүү дээ. Төрийн өндөр албан тушаалтан тангаргаа өргөхдөө авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна гэсэн мөртөө тангаргаасаа няцаад ингээд ашиг, сонирхлын зөрчил гаргаад энэ Шинэ Монгол сургуулийн нөхдүүд улсын төсвөөр тоглож байгаа юм биш үү? Тэгээд тэр 10 сая төгрөгийнх нь төсөл үнэхээр амжилттай сайхан юм уу гээд асуухаар багш нар толгой сэгсэрч байна шүү дээ. Энэ чинь зүгээр л улсын мөнгийг өөрийнхөө сургууль руу шилжүүлээд ингээд хоорондоо улсын мөнгөөр тоглож байгаа л ажил гэж ер нь би ч хэлээд байгаа юм би энийг. Өчнөөн олон сургуулиас гомдол ирж байна. Тэгэхээр энэ дээр Наранбаяр сайд минь байр сууриа надад илэрхийлээд энэ олон түмэнд үгээ хэлж хүргэмээр байна. Энэ бол яг цэвэр ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг.

Дараагийн асуудал болохоор “Эрин” сургуулийн асуудал байгаа. Дуулиантай сүр дуулиантай Эрин сургуулийг ингээд улсын сургууль болголоо гээд ингээд зарласан. Гэтэл энэ энийг би буруутгаж байгаа юм биш. Гэхдээ яг хэдэн төгрөгөөр хэнтэй, хэний зөвшөөрлөөр ямар гэрээ хэлэлцээр энэ сургууль хийж энэ сургуулийг авсан бэ? Жишээ нь, 2025 оны төсөвт энэ сургуулийг хэдэн төгрөгөөр аль төсөв дээр тавьсан юм? Энэ ямар ч тодорхойгүй. Ингээд дандаа ийм хууль бус далдуур ийм ажил хийгээд яваад байгаа чинь үнэхээр таалагдахгүй байна. Тэгээд Наранбаяр сайд энэ 2 асуултад хариулж өг.

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр 1 зүйлийг засварлаж хэлэх хэрэгтэй. Би Шинэ Монгол сургуулийн төлөөлөл биш. Би Монголын боловсролын боловсролыг сургуулиудыг сайн удирдлагатай, сайн менежменттэй, сайн чанартай сургалт явуулах зорилгоор л ажлаа хийж байгаа хүн. Та ингэж хүн гүтгэж болохгүй. Энийг, энэ үгийг буцааж авахыг би шаардаж байна. 1 дүгээрт.

Хоёрдугаарт энд сургуулийн менежментийг сайжруулах зорилгоор 3 ч төсөл энэ яамнаас хэрэгжсэн байдаг юм. Азийн хөгжлийн банктэй хамтраад, Нийслэлийн Боловсролын газартайгаа хамтраад сургуулиудыг 3 ангилаад 1, 2, 3 дугаар зэрэглэлд оруулаад эд нар ингээд явж байгаа 2 жишээ нь энэ 2 төсөл байна.

Гурав дахь нь таны дурдсан төсөл. Энэ төсөл бол 120 сургууль дээр энэ төвийн бүсийн энэ Сэлэнгэ аймгууд, Дархан тэгээд л энэ нийслэлийн сургуулиуд ингээд 120 сургууль. Төрийн өмчийн 700 гаруй сургуулийн 120 дээр нь хэрэгжээд явж байгаа нь үнэн. Энэ сургуулиудын өөрсдийнх нь тавьсан хүсэлтийн дагуу явж байгаа ийм төсөл. Би зүгээр ингээд сонсоход 300 гаран сургууль хүсэлтээ өгөөд 120 сонгогдсон гэж сонссон. Энэ дээр сургуулийн багаар ажилладаг, хүүхдүүдтэй багаар ажилладаг, багш нар нь багаар ажилладаг болж. Хүүхдийг хөгжүүлэх, хичээлээс гадуурх дугуйлан секцийг хөгжүүлэх эд нар гээд янз янзын ийм ийм ажил хийгдэж байгаа гэж би дуулсан. Энэ доторх асуудлыг нь та хэрэгжүүлж байгаа тэр байгууллагаас нь асуух хэрэгтэй. Ямар ч байсан 1 ч гэсэн сургууль

сайн болоосой гэсэн ийм л төсөл явж байгаа. Энэ бол ийм төсөл явж байгааг би танд хэлье.

“Эрин” сургуультай холбоотой тэр БГД-ийн 29 дүгээр хорооны нутаг дэвсгэр дээр Гурвалжингийн гүүрний цаана байгаа 1 ээлждээ 960 хүүхэд авч болох олон улсын стандартад нийцсэн Япон маягийн ийм стандартад нийцсэн ийм 10 мянга гаруй метр квадрат талбай, гаднаа хөл бөмбөгийн талбайтай, 1 урлагийн заал, 2 ч сагсны талбайтай ийм барилгыг худалдан авах үйл ажиллагаа явагдсан. Санхүүгийн түрээс энэ. Энэ нуусан юм байхгүй ил тод. Яахаараа нуусан юм гэж байдаг юм? Та бас ийм хариуцлагагүй ярьж болохгүй. Ил тод хийгдсэн ажил байгаа. Энэ дээр хотын дарга Нямбаатар, яг тэр тойргоос сонгогдсон гишүүн Ганхуяг нартай л та ярьж доторх нарийн юмыг нь асуу л даа. Нэлээн сайн хэлцэл хийгдсэн. Боловсролын яам тэр байгууллагатай нь сайн хэлцэл хийгээд маш энэ чинь эхлээд өндөр үнэлгээтэй явсан. Энийг нь 3 жилд хувааж төлөхөөр ингээд эхний санхүүжилтийг нь түрээсийн санхүүгийн түрээсийн хэсэг дээр нь Ганхуяг гишүүн өөрөө хөөцөлдөж байгаад оруулж ирсэн шүү дээ. Ийм хэмжээний сургуулийг бид нар авч байгаа ийм түрээснийх нь, санхүүгийнх нь түрээснийх нь энэ зардлыг нь төсөв дээр тавиулж байгаа юм.

Хариултын минут нэмэх билүү? Дэгийн дагуу нэмж хариулт байхгүй.

Ч.Ундрам: Энэ Эрин гээд байгаа сургуулийг төрд авах шийдвэр нь Засгийн газрын тогтоолоор авсан юм уу? Яг ямар хууль эрх зүйн хүрээнд худалдан авах ажиллагаа нь явагддаг юм бол?

Наранбаяр гишүүн хариулаарай.

П.Наранбаяр: Тийм тэгэхээр энэ дээр нууц юм байхгүй шүү. Ганхуяг гишүүн бас ороод ирлээ. Тэгээд энэ дээр одоо тэнд 1300 гаруй хүүхэд сурч байна. Өмнө нь хувийн сургууль байхдаа 200 гаруйхан хүүхэд сурдаг ийм л байсан. Одоо тэнд үнэхээрийн тэнд бөөгнөрсөн хүүхдүүдийн маш их эрх зөрчигдөж байсан, ээлжийн коэффициент нь 3 руу орчих гээд байсан энэ байдал эрс сайжирч эхэлсэн. Бид цаашдаа санхүүгийн түрээсээр ингэж хийх ажлыг эрчимжүүлнэ ээ санхүүгийн түрээсээр. Ингэж төр өөрөө цагаа ч хэмнэнэ мөн одоо хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллана. Энэ Засгийн газарт бид тогтоол оруулсан. Тэр тогтоол дотор нь санхүүгийн түрээс гэсэн үг нь орчихсон байгаа. Ийм байгаа.

Тэгэхээр ийм юмыг ингээд л гаргаж ирээд хаанаас юм дуулсан юм, юу болсон юм? Ингэж хариуцлагагүй мэдэгдэл хийхгүй байхыг би танаас хүсэж байна шүү. Юу яриад байгаа юм бэ? Адилхан танаар дандаа хэлүүлнэ гэж юу байдаг юм. Би бүх зүйл нь ил тод байгаа зүгээр.

Ч.Ундрам: Хасуурын Ганхуяг гишүүн энэ Эрин сургуультай холбоотой асуудлаар мэдээлэл өгье.

Х.Ганхуяг: Ямар асуудал үүсээд ингэж яриад байгааг нь би сайн ойлгохгүй байна л даа. Бид нар үндсэндээ Улаанбаатар хотын хувьд түгжрэл номер 1 асуудал болсон. Тийм учраас бид нар 20 минутын хот гээд хууль хүртэл баталлаа. 20 минут гэдэг учир юу вэ гэхээр бид нар зөвхөн зам барих биш, Үндсэн хуулиараа бид нар хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой юм. Хүүхдүүдийг сурах эрхийг нь өгөх ёстой. Тэр нь юу вэ гэхээр Улаанбаатар хот, би БГД-т ч хэлье, бусад дүүргүүдэд ч

хэлье. Манайх чинь 6500 хүүхэдтэй сургууль байна шүү дээ. 960 хүүхдийн сургууль 6500 хүүхэд явж байгаа.

Тэгээд энэ яагаад ингэдэг вэ гэхээр шинээр үүссэн хотхон сургууль байх ёстой газраа сургуулиа бариагүйгээс болоод хуучин сургуулийнхаа хажууд нь, бөөрөн дээр нь аваачаад л хөл бөмбөгийн талбайг нь байхгүй болгоод л ингээд л өргөтгөл нэмээд л нэмээд л нэмээд л нэмээд л ингээд л явчихсан. Одоо манай БГД-ийн ихэнх сургуульд тийм байна. Өргөтгөлөөр асуудал шийдэхээр яаж байна гэхээр түгжрэл нэмэгддэг. Мөн эргээгээд өглөө, орой болгон хүүхдээ хүргэж өгөх асуудал үүсдэг. Тэгээд бид нар ерөөсөө л хийх ёстой ажил юу вэ гэхээр яг тэр гэрээсээ ойрхон сургууль, цэцэрлэгийг нь шийдэж өгөх ёстой юм. Цэцэрлэг бид нар 2022 онд би өөрөө төсвийн боловсролын салбарын ажлын хэсгийн ахлагчаар ажилласан юм. Тэгэхдээ нийтдээ бас энэ сугалааны цэцэрлэг гэдэг асуудал байхгүй болгосон байхгүй юу. Сугалааны. Тэгээд түрээслэхийг нь түрээслээд, тэр төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллахыг нь ажиллаад ингээд цэцэрлэгийн асуудал 100 хувь шийдсэн.

Өнөөдөр Улаанбаатар хотод тулгамдаж байгаа хамгийн том асуудал ялт ч үгүй сургуулийн асуудал байгаа үлдчихээд байгаа. Яармаг дээр очвол та нар тэнчээ 1 ч төрийн сургууль олохгүй. Хан-Уул руу та нар яваад үз. Тэгээд бид нар боломжтой газар нь тэр хувийн хэвшлээрээ барьчихсан байвал түрээсээр, санхүүгийн түрээсээр, төрийн хэвшлийн түншлэлээр энэ сургуулийн асуудлыг шийдэхгүй бол бид нар хэзээ ч шийдэж чадахгүй. Дандаа хөрөнгө оруулалтаар шийднэ гэж байхгүй. 1 сургууль барихын тулд хамгийн багадаа 3-4 жил ордог. 3-4 жил ордог. Барьж байх явцдаа төсвийн өртөг нь нэмэгдээд явчихдаг. Харин энэ Наранбаяр сайд, Нямбаатар дарга эд нар бид нарын энэ хийсэн ажил төсөвт асар их юмны хэмжээний хэмнэлттэй шүү. Одоо яриад байгаа тэгээд Эрин хороололд нийтдээ 3000 хүүхэд байгаа. Бүгдээрээ нэг бол тэр том том замыг алгасаж СХД-ийн сургуульд ордог. Тэндээ багтахгүй болохоороо наашаагаа тэр 10 дугаар хорооллын сургууль руу өглөө, орой болгон явдаг. Тэнд нь ачааллыг дийлэхээ больчихсон ийм л нөхцөл байдалд байгаа юм.

Сургуульд, хүүхдүүдэд мөнгө зарахаас та нар энд өнөөдөр ерөөсөө эмээж болохгүй шүү. Бид нар ерөөсөө энэ төсвөөр Улаанбаатар хотод, тэр тусмаа бид нар зам барих ёстой, метро барих ёстой. Гэхдээ үүний зэрэгцээгээр нийгмийн үйлчилгээг бид нар хамтад нь өгч байх ёстой юм, ойртуулж өгөх ёстой юм. Хамгийн сайн сургууль бол гэрт ойрхон сургууль шүү. Хамгийн сайн сургууль. Тэгээд тэр гэрт ойрхон сургуулийн бид нар олон улсын стандартын дагуу хөрөнгө оруулалтыг нь хийдэг, багш нарыг нь хөгжүүлдэг, шаардлагатай компьютер цахимын юмнуудыг нь хийж өгдөг. Ингэж байж л энэ Монголын хүүхдүүд энэ.../минут дуусав./

Ч.Ундрэм: Дараагийн асуулт Бямбасүрэн гишүүн асууя.

Ш.Бямбасүрэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой юм асуучихъя.

Ер нь энэ манай энэ Монгол Улсад энэ хэрэгжүүлж ирсэн энэ олон сангууд ер нь яг угтаа энэ ач холбогдол, зорилгын хувьд энэ маш зөв зүйтэй ингээд ийм сангууд байгаад байгаа юм. Гол нь энэ хэрэгжүүлэх явцдаа энэ дүрэм, журмаа зөрчсөн, ашиг сонирхол гаргаад ингээд явчихсанаас болоод энэ олон сангууд ингээд нэр хүндгүй болчихоод байгаа юм. Одоо энэ манай энэ Боловсролын

зээлийн сан бол үнэхээр Монгол Улсад бүр туйлын хэрэгтэй, энэ ирээдүйд бид нар энэ боловсон хүчнээ бэлдэхэд үнэхээр чухал ач холбогдолтой ийм сан байгаад байдаг юм. Гэтэл одоо ингээд бид нар ингээд өнгөрсөн юм уу ингээд явж ирсэн юмаа ингээд харахаар үнэхээр хүнд байгаад байна л даа.

Тэгэхээр энэ дээр яаралтай бид нар энийг засаж сайжруулмаар байгаа юм. Тэр асуулт 1 дээр өгч байгаа тэр тасралтгүй 15 жил гэдгийг тэр Засгийн газрын 103 дугаар тогтоол дээр байгаа тэр заалтыг Наранбаяр сайд та яаралтайгаар байхгүй болгомоор байна. Тэгээд энэ яг Засгийн газрын тогтоол учраас та өөрөө Засгийн газрын хуралдаан руугаа оруулаад ингээд засчих тийм боломжтой зүйл байна. Тэгээд энэ дээр яаралтай энийг хиймээр байна. Энийг ер нь хэзээ хийх вэ гэж би асуумаар байна.

Тэр Монголбанкны зээлдэгчдийн зээлийн мэдээллийг нийлүүлэх бэлтгэл ажил хангагдаж байна гэж байна. Энэ ер нь тэгээд ямар хугацаа шаардах юм бэ? Хэзээ дуусах юм бэ? Бид нар ингээд ажил хийвэл жоохон хугацаатай эд нар ярьдаг болмоор байна. Тэгээд яг хэзээ энэ ажил хийгдэж дуусах юм бэ гэсэн 2 асуултыг асууя.

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээрээ тэр тасралтгүй гэдэг үг нь өөрөө би андуураагүй бол Боловсролын ерөнхий хууль дээрээ байж байгаа тийм ээ. Хууль дээрээ аваачаад тийм хатуу заагаад хаячихсан тасралтгүй гээд ,тэгээд 15 жил гээд. Тэгэхээр тэр хуулийн заалт өөрөө ийм тасралтгүй гэдэг үг орчихсон учраас хуулиа өөрчлөхөөс нааш ийм болохгүй л юм болчихоод байгаа юм. Би аль болохоор л энэ дээр уян хатан хандсан л ийм байгаасай л гэж өөрөө хувь хүний хувьд хүсэж байгаа юм.

Монголбанк руу явуулах мэдээллийн тухайд энэ нэлээн нягтлах шаардлагатай байгаа. Түрүүн би хэлсэнчлэн, миний зүгээс хэлсэнчлэн тэр чөлөөлсөн тушаалуудыг захиргааны актынх нь хувьд хэрхэн үзэх вэ гэдэг энэ хуульчийн дүгнэлтүүд гарчихсан байгаа. Харин түүнийг хүчинтэй, хөөн хэлэлцэх хугацааны асуудал ч гэсэн байгаа. Ингээд энэ асуудлууд дээрээ бид Засгийн газраар оруулж хэлэлцээд гээд та бүхэнтэй бас ярилцаад ингээд шийдсэний дараа яг энэ дээр үүргээ биелүүлсэн, биелүүлээгүй гэдгийг ялгаж салгах ийм боломж гарч ирж байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр зэрэг одоо энэ асуудлаа бид энэ улиралдаа багтаагаад ер нь хийчих боломжтой болов уу гэж ийм бодолтой байна.

Ч.Ундрам: Энэ төрийн өмчийн сургуульд тасралтгүй 15 жил багшилж байгаа багшийн 1 хүүхдийг төрийн өмчийн их сургуульд үнэ төлбөргүй сургана гээд энэ заалт байгаа шүү дээ. Энийг манай гишүүд энд ярьж байгаа. Эрдэнэбат гишүүн Мөнхтуяа гишүүн ч гэсэн ярьдаг. Бямбасүрэн гишүүн та хэд Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд хууль санаачлаад өөрчлөлт оруулж болно. Тийм, энэ бол дэмжигдээд бид нар бас засах ёстой юм гэж бодож байна. Удахгүй өргөн мэдүүлэх байх тээ? Аан D-Parliament дээр байрлуулаад санал авч байгаа юм байна. Тэгэхээр манай бас багш нар энэ D-Parliament руу ороод энэ боловсролын багц хуультай холбоотой санал, хүсэлтээ цахимаар өгөөд, үүний дагуу бид нар хуулиа хэлэлцээд явна гэж хэлмээр байна.

Дараагийн асуултыг Саранчулуун гишүүн асууя.

О.Саранчулуун: 5 асуудлыг хөндөх гээд байгаа юм. Боловсролын зээлийн сан бол энэ хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч гээд мэргэжилтнүүдийг дэмжихээр болж байгаа боловч хүсэлт ирээгүй байна гэж байгаа. Тэгэхээр үүний цаадах асуудлыг нь ер нь гаргалгааг нь ингэвэл хүүхдүүд нэмэгдэх юм байна гэдэг ийм шийдлээ олсон уу гэдэг асуудал байгаа.

Хоёрт нь болохоор ер нь энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах мэргэжил шүү дээ янз бүрийн өвчин эмгэг осол, гэмтлээс болоод өөрийгөө илэрхийлж чадахгүй, эргэж нийгмийн харилцаанд орж чадахгүй, алдагдсан тэр чадварыг нь эргэн сэргээх ийм л мэргэжилтнүүд байгаа. Тэгэхээр энэ ядарсан хүмүүстэй ажилладаг мэргэжилтнүүд хамгийн сайн хүмүүс тэдний эцэг эх л байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр ээж аавуудыг 2 дахь удаагаа суралцах боломж ер нь байна уу гэдгийг би дахиж асуумаар байгаа. Хэдийгээр энэ дээр дандаа анх удаа сурч байгаа гээд хэлчихсэн. Гэтэл нэгт анх удаа сурч байгаа хүмүүсийг гээд хэлчихсэн. Хоёрт эдийн засгийн хувьд өндөр үр өгөөжтэй тийм мэргэжилтнүүдийг гэхчигсэн байгаа.

Гэтэл нийгмийн эмзэг бүлэгт гэдэг юм уу, өвдсөн энэ бүлэгтээ ажиллах мэргэжилтнээ бэлдэхгүй бол бид нар энэ хүмүүсээ сэргээж авч чадахгүй л дээ. Дахиад л халамжийн мөнгөө ярьсаар л байх болно. Яг энийг энэ асуудлыг үргэлжлүүлээд би энэ протезын мэргэжилтнүүдийг асуумаар байгаа юм. Монгол Улсад өнөөдөр хиймэл гар, хөл хийдэг протезын мэргэжилтэн 2 л байгаа. 1 нь удахгүй бараг тэтгэвэртээ гарч байгаа байх. Гэтэл жил болгон бид нар сахрын өвчнөөс болж байна, ослоос болж зөндөө олон хүмүүс хөлгүй, гаргүй болж байгаа шүү дээ. Энэ мэтчилэн ингээд хүн нь, нөөц нь хэрэгтэй байгаа энэ мэргэжилтнүүдээ дэмжих асуудлаар ер нь ямар шийдлүүд байна вэ гэдгийг асуучихмаар байгаа.

Дараагийн асуудал нь тэр 2 дахь мэргэжлээр суралцах шийдвэрийг гаргаад өмнө нь болно гэж хэлээд хэдэн ээжүүд орсон байгаа. Одоогийн байдлаар 26 хүн материалаа өгөөд 7 ээж сурч байгаа. Энэ 7 ээж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асрахын хажуугаар давхар өөрөө өөр бусад хүний хүүхдэд тусалдаг мэргэжилтэн болох гээд өнөөдөр сурч байгаа. Энэ хүмүүсийн энэ төлбөрийг нь ингээд нэгэнт болно гэж авчхаад эргүүлээд нөхөж төлөөд өгөх боломж байдаггүй юм уу? Журмаар биш төсөв нь байвал тэр тушаалаар ч байдаг юм уу энэ дээр ямар шийдэл байх вэ гэдгийг яг асууя. Яагаад гэвэл ээжүүд маань бас энийг заавал дуулгаж өгөөрэй гэж хэлсэн юм.

Үргэлжлээд би дахиад зүйл байгаа нь багш гэдэгт ер нь ЕБС-ийн багш МСУТ-ийн багш 2-ыг дурдаад байгаа юм л даа. Тэгэхээр их сургуулийн багш нар багш биш юм уу? Энэ багшийн хүүхэд гэдэг дээр чинь их сургуулийн багш нар орж байгаа юу, үгүй юү гэдгийг бас лавлаж асууя. Баярлалаа.

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ ер нь яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тусалдаг, энэ чиглэлээр ингээд эцэг эх нь хамгийн сайн сурдаг хүмүүс нь эцэг, эх нь өөрсдөө юм байна лээ л дээ. Уулзаад, үзээд ингээд явахад үнэхээрийн өөрөө зовлонг нь сайн ойлгодог, илүү сайн мэдэрдэг, тэгээд тийм учраас туслах ийм мэргэжил эзэмших хүсэл эрмэлзэл ч өндөр байдаг. Би ч бас хэд

хэдэн эцэгтэй уулзаж байхад ярьж байсан. Боломж нь байгаад байхад нэгдүгээрт энэ ирэхгүй байна гэдэг энэ хэл засалчийн асуудал ч гэсэн ингээд ярихад энэ мэдээлэл нь сайн хүрэхгүй байгаа бас магадлал өндөр Нэмэгдүүлэх тал дээр. Мөн бид цаашдаа бас энэ мэргэжлийн зөв ойлголтыг, зөв ойлголтыг бид бас хүмүүстээ хүргэх ийм шаардлагатай гэж бодож байна.

Ер нь энэ протезын мэргэжилтэн гэдэг юм уу яг ийм хүмүүсийг дэмжсэн энэ сургалт руу бид онцгой анхааръя. Монгол Улсын хэмжээнд 2-хон байна гээд. Ингээд 2-хон байна, 1 нь тэтгэвэртээ суух гэж байна гэвэл энэ чинь хийх ийм хүн зайлшгүй шаардлагатай болно. Тэр төлбөрийг нөхөж олгох тал дээр бид бас судалж үзье. Тэгэхдээ энэ шууд хариулахад бас, энд шууд хариулж арай л барамгүй юм байна шүү. Нэгэнт болоод явчихсан энэ харилцаа ингээд яваад өнгөрчихсөн учраас төлбөрийг нь нөхөж олгох ийм юу бол манай энэ журам дээр одоогоор байхгүй.

Тэр 15 жил ингээд багшилж байгаа их сургуулийн багш ч гэсэн орж болох уу гэдэг нь ерөөсөө энэ хуулиараа СӨБ болон ерөнхий боловсролын багш гээд заачихсан байгаа. Энэ болохоороо тэгэхээр хуулийн л ойлголт болно. Мэдээж таны хэлдэг үнэн багшилж байгаа хүн хаана ч багшилж байвал багш л хүн. Гэхдээ энэ хуулиараа СӨБ болоод ЕБС гээд орчихсон байгаа.

Ч.Ундрам: Дэгээрээ нэмж асуулт авч болохгүй Саранчулуун гишүүн. Сийлэгмаа дарга бас нэмэлт нэлээн бас нарийн тоо баримт түрүүн асуугаад байсан. Яг хэдэн хүн энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах мэргэжилд өргөдөл өгөөд хэд нь тэнцээд ингээд явж байгаа юм бэ гээд. 8 номерын микрофон.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжил олгох сургалт, ном, сэтгэл зүйч, хоол зүйч гээд эдгээр мэргэжлүүдээр гадаад дотоодод суралцах боломж нь одоогийн 102 дугаар тогтоолоор нээлттэй байгаа. Дотоодын зөвхөн сэтгэл судлалын мэргэжлээр цөөхөн хүсэлт ирж 24 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр олгосон байгаа. Энэ чиглэлд зарим эрэлттэй мэргэжлээр 112 хүнд олгосон байгаа. Нэг.

Хоёрдугаар асуулт нь түрүүний багш мэргэжлийн тухайд багшийн Боловсролын ерөнхий хуулиар төрийн өмчийн ерөнхий боловсрол болон тусгай мэргэжлийн сургууль, СӨБ-ын багш нар гээд заачихсан учраас их, дээд сургуулийн багшийн 1 хүүхдийн 15 жил гэдэг заалт хэрэгжихгүй байгаа. Эрэлттэй, тэр түрүүний протезын мэргэжил гэдэг дээр яг Дээд боловсролын, Боловсролын яамны Дээд боловсролын газар дээр судалгаа хийгдсэн. Нийтдээ Монгол Улсад хиймэл эрхтэн хийх 70 мэргэжилтний хэрэгцээ байгаа. Тухайн 70 мэргэжилтнийг яг аль нэг сургууль дээр хөтөлбөр хэрэгжүүлээд хэрэгжүүлэхэд буюу хөтөлбөрт элсүүлээд суралцуулахад хэрэгжих боломжгүй байгаа учраас гадаадад ойрхон суралцах боломжийг нь эрэлттэй тэргүүлэх мэргэжилд энэ жагсаалтыг оруулах байдлаар санал тусгачихсан байж байгаа. Одоогийн байдлаар.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон санхүүжилтийн тоо сүүлийн 5 жилд нийтдээ 2917 иргэнд 5.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байгаа. Үүнээс 24 онд 548 иргэнд 1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байгаа.

Ч.Ундрам: Дараагийн асуулт Аубакир гишүүн асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Би энэ Байнгын хорооны гишүүн биш ээ. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд Байнгын хороотой холбоотой, салбартай холбоотой ганц асуулт байна. Наранбаяр сайдаас.

Багш нар асуугаад өгөөч гээд байдаг юм. Энэ хувийн сургуульд ажилласан жилийг улсын сургуульд ажилласан жилтэй адилтгаж ч юм уу ижил түвшинд авч үздэггүй? Дараа нь улсын сургуульд орохоор хувийн сургуульд 10 гаруй жил багшилчихсан багш нарын ч жил нь тоологддоггүй бололтой. Энийг асуугаад нэг тийш нь шийдэж өгөөч ээ гэсэн хүсэлтийг иргэдтэй уулзахад, салбар салбарынхантай уулзахад тавьж байгаа санал байгаа юм 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт маань Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд сонгогдсон тойргууд дээрээ боловсролын салбарын аж ахуйн чанартай асуудлуудад анхаарал хандуулж явдаг. Энэ маань сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, хүртээмжийн асуудлыг тухайн сонгогдсон тойрог дээрээ асуудлыг Улсын Их Хуралд дэвшүүлээд, тойргийнхоо асуудлыг шийдүүлэх бүрэн эрхийнхээ хүрээнд шийдээд явж байгаа аж ахуйн чанартай асуудлыг. Наранбаяр сайдыг ажиглаад байхад энэ сайд болсноосоо хойш энэ боловсролын салбарыг улс төржүүлж байна. Аж ахуйн чанартай ажлыг чинь Улсын Их Хурлын гишүүд хийгээд өгчхөж байгаа. Сая Ганхуяг гишүүн ч гэсэн хэлээд гарлаа тойргийнхоо асуудлыг. Боловсролын салбар бол үндсэндээ ХҮН намын хүний нөөцийн газар шиг болсон шүү. Сая бид нар тойрог дээрээ сар орчим ажиллаад ирсэн. Боловсролын салбар чинь бужигначихсан байна шүү дээ. Сургууль, цэцэрлэг сая та өглөө мэдээлэл хийж байна лээ засгийн хурлын дараа. Наадах чинь албан хариуцлагатай мэдээлэл биш байна гэж. Би хариуцлагатайгаар хэлчихье. Тийм болчихсон юм. Таны томилсон хүмүүс чинь сургуулийн, цэцэрлэгийн захирал дээр очоод ХҮН намын үнэмлэхийг ав, авахгүй бол ажлаа өг. Энэ нууц биш шүү. Би хариуцлагатай Улсын Их Хурлын гишүүнийхээ хэмжээнд би энэ асуудлыг тантай бас өмнө нь ярьж байсан.

Тийм учраас энэ боловсролын салбарыг Америкийг та бүхэн харж байгаа байх Ерөнхийлөгчөөсөө эхлээд энэ боловсролын салбартаа ач холбогдол өгөөд эхэлчихлээ. Хятад Улс бол хэдэн мянга хэдэн зуун жилээр энэ боловсролынхоо салбарт анхаараад ирсэн. Таныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд болоход чинь намаа бэхжүүл гэж энэ салбарыг өгөөгүй байлтай. Тийм учраас энэ асуудлыг цаашдаа ингээд байгаад байх юм уу? Аж ахуйн чанартай ажлыг чинь Улсын Их Хурлын гишүүд тан дээр заалгахгүй хийчихнэ. Та энд ирснээрээ Монгол Улсын боловсролын чанар ирээдүй болсон хүүхдүүдийн боловсролд яаж чанартай боловсрол өгөх вэ гэж санаа зовох ёстой болохоос биш ХҮН намаа яаж бэхжүүлэх вэ гэж та бодож ажиллах ёсгүй.

Тийм учраас энэ асуудал чинь цаашдаа үргэлжлэх юм уу? яах вэ дээ удахгүй хамтарсан засгаас гарна гэдгээ та сайн, маш сайн мэдэж байгаа. Жаргал байгаа цагт жаргалын бага амттай гэдэг юм. Байгаа дээрээ жаргаад намаа бэхжүүлээд авчихъя гэж бодож байгаа юм уу? Тийм учраас багш нар чинь бужигначихсан байна. Энэ.../минут дуусав./

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариульъя.

П.Наранбаяр: Тэгэхээр төрд ажилласан, улсад ажилласан жил гээд ингээд яригдаж байгаа. Ер нь улсад ажилласан жил гэвэл та өөрөө ч мэдэж байгаа шүү дээ ер нь юугүй, тэр ямар нэгэн ялгаварлал байхгүй. Харин Боловсролын ерөнхий

хууль дээр хувийн хэвшилд ажилласан бол ингээд ийм нэлээн ялгавартай заалт байдаг тийм. Энэ тэгэхээр зэрэг ийм заалтыг та хөндөж байх шиг байна. Тийм тийм үнэн үнэн. Тэгэхээрээ энэ таны бас 13-ын жишээлбэл 3.6 дээр төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсролын сургууль, политехник, коллежид 15-аас доошгүй жилд тасралтгүй ажилласан багш, ажилтны 1 хүүхдийг гэх мэтээр ингээд иймэрхүү заалтууд олон байдаг. Тэгэхээр нэлээд бий.

Тэгэхээр энэ дээр бас ийм ялгаварлал үүссэн байна гээд ийм шүүмжлэл явдгийг хүлээн зөвшөөрнө. Энэ түрүүнд энэ тасралтгүй гэдэг үгийг ч гэсэн ер нь авч хаях нь зүйтэй гэсэн ийм ярьж байна. Тэгэхээрээ аль салбарт ажилласан нь хамаагүй энэ багш нарыг ингэж бас нийгмийн баталгаа болгохдоо ялгаварлах нь бас зохимжгүй байна гэсэн ийм дуу хоолой байдгийг бас та хэллээ.

Боловсролын салбарт улс төржиж байгаа эсэх асуудал, Баян-Өлгий аймагт улс төржиж байгаа эсэх асуудлыг та бас яриад байна. Ажил урагшаа явах ёстой. Баян-Өлгий аймгийн өнөөдрийн элсэлтийн шалгалтын дундаж оноо өсөх, цаашдаа энэ тэнд бас болохгүй байгаа асуудлууд нь шийдвэрлэгдэх ийм л шаардлагатай гэж үзэж байгаа болохоос биш би тэнд ямар нэгэн улс төржүүлэх ийм юм хийх сонирхол байхгүй, тийм юм байхгүй. Түүний зэрэгцээ ер нь хос хэлний хөтөлбөрийг боловсруулж, тэнд хурдан нэвтрүүлэх, Монгол хэл заах явдлыг дэмжих, Казак хэлээрээ боловсрол эзэмшихийг нь дэмжих, Тува хэлээр эзэмшихийг дэмжих гэх мэтийн бидний өмнө тулгамдсан асуудлууд олон байгаа. Энэ болгоныгоо шийдвэрлэхийн тулд л бид урагшаагаа явна гэж байгаа. Бид бол ХҮН нам нь энд ирээд л ингээд л Засаг барилцаад жаргаад байгаа юм алга. Ачаа л үүрэлцэж байна. Тийм, жаргаад байгаа юм байхгүй, ачаа л үүрэлцэж байна. Тэгэхээрээ зэрэг бид ачаагаа л үүрч, энэ боловсролын салбарыг сайжруулахын төлөө, чанарыг нь дээшлүүлэхийн төлөө л явж байгаа. Миний зүгээс ямар нэгэн тийм ХҮН намын үнэмлэх харж хүнийг ажилд томилсон явдал байхгүй. Баярлалаа.

Ч.Ундрам: Хосбаяр гишүүн асуулт асууя. Энэ Дэгийн хуулиараа асуулга дээр тодруулга байхгүй.

Г.Хосбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Малчны тухай хууль 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлж байгаа. Тэгэхээр энэ хууль дээр малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны 1 хүүхдийг мал аж ахуйн тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах гэсэн ийм хууль хэрэгжээд эхэлчихсэн байгаа.

Тэгэхээр үүний энд суралцаж байгаа хүүхдүүдийн тэр сургалтын төлбөрийн эх үүсвэр энэ Боловсролын зээлийн сан дээр байдаг юм уу, Боловсролын яамны хаана нь байна? Энэ 1 сарын 1-нээс хойш ер нь энэ хөтөлбөрт хамрагдсан энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой бас ажил хэр урагшилж байна? Цаашдаа ер нь энэ дэмжлэг авах уу? Энэ малчид бас нэлээн асуугаад, сураглаад байгаа ийм зүйл байгаа. Энэ дээр хариулт өгөөч гэж.

Ч.Ундрам: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр малчны энэ дэмжих энэ хуульд заасан энэ заалт их хэрэгжинэ. Боловсролын зээлийн санд энэ эх үүсвэр нь тусаад орж байгаа. Тэгээд яг энэ таны түрүүнд хэлсэн чиглэлээр энэ энэ намрын элсэлтээс эхлээд үнэ төлбөргүй яг бэлчээр судлал, бэлчээрийн чиглэлээр суралцах ийм боломжоор

ингээд хангагдаж байгаа. Түүний зэрэгцээ бид энэ журмынхаа шинэчлэл дээр энийгээ оруулж байгаа. Тэгэхээр энэ 26 оны, 25-26 оны хичээлийн жилд ингээд бүрэн тусаад явах боломжтой. Ийм байгаа. Баярлалаа.

Ч.Ундрам: Гишүүд асуулт асууж дууссан учраас асуулт тавьсан гишүүн Батнайрамдал 5 минут үг хэлнэ.

О.Батнайрамдал: Баярлалаа. Боловсролын зээлийн сан, энэ сан дотор маш олон булхай олон жил угжирч явсан. Яг энэ асуудлыг гаргаж ирээд яг 2 жилийн ой болж байгаа юм байна. 2 жилийн ой. Яг 2 жилийн өмнө 3 сард энийг гаргаж ирж, олон нийтэд хүрч, олон нийтийн бухимдлыг маш их гаргаж байсан.

Боловсролын зээлийн сан өөрөө магадгүй манай татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжиж байгаа энэ 24 тусгай сангийн хамгийн үнэ цэнтэй хөрөнгө оруулалт хийдэг сан нь Боловсролын зээлийн сан гэж миний хувьд боддог. Энэтэй олон хүн санал нэгдэх байх. Оюутан, залуучууд руугаа татвар төлөгчдийн мөнгөөр хөрөнгө оруулалт хийгээд, эргэж өндөр боловсролтой иргэн болоод эх орондоо хувь нэмрээ оруулахад нь гүүр нь болдог энэ боломж дандаа л Боловсролын зээлийн сан байж ирсэн. Ийм зорилготойгоор анх 1992 онд байгуулагдаж байсан түүхтэй.

Харамсалтай нь энэ 30 жилийн хугацаанд энэ чинь бүгдийг нь нийлүүлээд тооцох юм бол бараг 1 их наяд гаруй төгрөгийг татвар төлөгчдийн мөнгийг гэсэн үг зээл, санхүүгийн дэмжлэг болгож, энэ дотор зээл ч орно, тэтгэлэг ч орно, буцалтгүй тусламж ч орно. Хэлбэрээр олгосон. Харамсалтай нь энэ их мөнгөний энэ 1 их наяд төгрөгийн татвар төлөгчдийн мөнгөний хуваарилалт дандаа шударга бус, ил тод бус, энэ дотор үнэхээр л дарга цэрэг нарын хүүхдүүд авсан, ардын хүүхдэд очдоггүй ийм яг л ийм л жишиг явж ирсэн.

Өнөөдөр ч гэсэн Боловсролын зээлийн сангийн асуудал гаргаж ирээд 2 жил болж байхад дорвитой шийдэл гараад шийдэгдсэн үү гэвэл бүгдээрээ асуултын тэмдэгтэй байсаар л байна. Өнөөдөр Боловсролын зээлийн сангийн дотоод зээл бараг 500 гаруй гарсан, тэрбум төгрөгийн зээл олгогдсон. Эргэн төлөлт нь 98 хувьтай. Оюутан хөгжлийн зээлээр зээл авсан сурагчид эргэн төлөлтөө маш сайн хийдэг. Хэрвээ эргэн төлөхгүй дипломыг нь хураадаг. Монголбанкны зээлийн мэдээллийн санд орсоор ирсэн. Сүүлийн 9 жил орсоор ирсэн. Өнөөдөр Боловсролын зээлийн сан дээр 15 гаруй мянган диплом одоо хүртэл хураалттай байгаа. Хэн ч ирж авдаггүй, тоодоггүй, хаясан, архивлагдсан байдаг.

Гэтэл гадаад зээл нэг ёсондоо гадагшийгаа сургуульд явахад хүүхдүүдэд санхүүгийн дэмжлэг болгож өгсөн 2500 гаруй хүүхдийн 360 орчим тэрбум төгрөгийн асуудалд эргэн төлөлт нь 4 хувь ч хүрэхгүй л ийм л дүнтэй байна. Энэ асуудлыг гаргаж ирснээс хойш эргэн төлөлт сая сайдын үгэн дээр дурдагдаад байна л даа 14 орчим тэрбум төгрөг гээд. Гэхдээ энэ чинь сүүлийн 30 жилийн хугацаанд төлөгдсөн 14 тэрбум шүү дээ. 24 оныг аваад үзэх юм бол ерөөсөө 2.4 тэрбум л төлөгдсөн байгаа юм. 2.6 тэрбум юм байна. Дэндүү чамлалттай байгаа юм. Бид нар энэ 360 тэрбум төгрөгийг тэгээд би хэзээ эргэн төлөгдөхийг хүлээх вэ? Буцаад эргэн төлөгдөхгүй бол Монголбанкны саарал жагсаалтад одоо хүртэл арга хэмжээ авна гэж явсаар байгаад яг 2 жил болж байгаа шүү. Асуудал гаргаж ирэхэд л Монголбанкны асуудал хөндөгдөж байсан. Одоог хүртэл яг 1 ч хүүхэд Монголбанкны зээлийн мэдээллийн санд ороогүй л байна. Энэ буцаад эргээд явж явж хүүхдийн, суралцагчдын, хүний эрхийг зөрчсөн асуудал шүү дээ. Хэний

хүүхдийн зээл Монголбанкны зээлийн жагсаалтад ороод, хэний хүүхэд нь одоо хүртэл орохгүй явна. Энд бүүр том утгаараа харах юм бол Үндсэн хууль зөрчсөн асуудал явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг ямар нэгэн шийдэл гаргаж бид нар заавал засах ёстой, засах ёстой. Энэ дээр олон нийтийн хүлээлт байгаа шүү. Монголбанк Боловсролын яам гэсэн 2 төрийн байгууллага яагаад мэдээллээ солилцож болдоггүй юм. Асуудал дэвшүүлж гаргаж ирээд 2 жил болж байхад одоог хүртэл тэр хүүхдүүдийн судалгааг хийж байна аа гээд. Авлигатай тэмцэх газар, Ерөнхий прокурорын газар бас хамтарсан ажлын хэсэг гараад л 1600 гаруй хүнийг ярилцлагад дуудсан байдаг. Үр дүн нь хаана байгаа юм бол? Одоог хүртэл бид нарт мэдээлэл байхгүй л.

2025 оны төсөвт түүхэн хэмжээндээ Боловсролын зээлийн санд 154.8, 158.4 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Үүний 33.6 тэрбум нь эргэн төлөлтөөр санхүүжнэ, бусад эх үүсвэрээр санхүүжнэ гэсэн.

25 онд 780 сая төгрөг л эргэн төлөгдсөн байгаа шүү. Биелэлтийг нь харах юм бол 2-3 хувьтай. Энэ хэзээ эргэн биелэх вэ гэдэг том.../минут дуусав./

Ч.Ундрам: Батнайрамдал гишүүн асуулт асуух уу? Дэгээрээ та асуулт асууж болно.

О.Батнайрамдал: Асуулт асуучихъя.

Тэгэхээр энэ олон нийтээс хүлээлттэй байгаад 2 том асуудал байгаа юм л даа. Боловсролын зээлийн сангаас ялангуяа энэ гадаад зээл авсан суралцагчид одоо хүртэл яагаад Монголбанкны жагсаалтад орохгүй байна вэ? Монголбанк мэдээллээ өгчих л гээд байгаа шүү дээ. Энэ асуултын хариулт дээр энэ дотоодын зээлийн мэдээллийн сан руу дотоодын зээлдэгчдийн явуулж байгаа мэдээллээ программаар хийдэг. Тэр программд нь гадаад зээлийн хүүхдүүд орох тохироогүй байна аа гэж байгаа юм. Энэ чинь юу гэсэн үг вэ? Энэ дээр хариулт авмаар байгаа юм. Зүгээр программын тохиргооноос болоод ингээд дотоод зээл авсан хүүхдүүдийг нь дарамталж зээлийн мэдээллийн санд оруулдаг. Гадаад зээл авсан хүүхдүүд нь хүртэл ороогүй. Ер нь сүүлийн 2 жилээс өмнө тэр талаар хэн ч хөөцөлддөг ч үгүй байсан. Тэр хүүхдүүд зээлээ тэтгэлэг, эсвэл буцалтгүй тусламж гэж ойлгож явсаар ирсэн шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгө авахаар яагаад тэрийг хэн нэгэн даргатай яриад цуцалчихна, чөлөөлчихнэ, ингэж ойлгодог юм? Бид нар Хаан банкнаас зээл авчхаад тэрийг нь хэн нэгэн даргатай яриад чөлөөлүүлчихнэ гэж ойлголт байдаг уу? Байхгүй шүү дээ.

Тэгэхээр энд дэндүү удаж байна. Яагаад төрийн байгууллага дээр очоод л яг мэдээлэл солилцох болохоороо хүнд суртал гараад эсвэл тэр нь болохгүй байна, энэ нь болохгүй байна гээд одоо хүртэл мэдээллээ солилцож болдоггүй юм. Энэ программын шинэчлэл гэдэг бол миний бодлоор хариулт биш. Ийм хариулт тавиад сууж байж болохгүй байна.

Хоёрдугаарт энэ оны төсвөөс өгсүүлээд 158.4 тэрбум төгрөгийн Боловсон зээлийн сангийн үйл ажиллагаа гэдэг бол түүхэн хэмжээндээ гарсан том дүн шүү. Энэ сайн хэрэг. Засгийн газраасаа анхаарч байна. Залуучууд руугаа хөрөнгө оруулъя гэж байна. Сайн хэрэг.

Гэхдээ энэ дүнгийн 33.6 нь буцаад зээлийн эргэн төлөлтөөс хийгдэнэ. Тэр 300 тэрбум төлөгдөөгүй байхад аргагүй шүү дээ. Энийгээ буцаад төсөвтэйгөө бид нар уяж байж эргэн төлөлт нь заавал хийгдэх ёстой. Эргэн төлөлт болгоны ард дахиад 1 хүүхдэд боломж олдоно гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бүгдээрээ хүнд суртал яриад ингээд баймааргүй байна л даа. Энэ дээр шийдэл гаргаад энэ зээлийн эргэн төлөлт дээр 33 тэрбум төгрөг төлөгдөнө гэдэг энэ том асуудал шүү. 2 жил бөөн асуудал болгож гаргаж ирээд олон нийтийг бухимдуулан байж 14-хөн тэрбум төлөгдсөн байна шүү дээ тээ? 14-хөн тэрбум. Тэгэхээр 33.6 тэрбум гэдэг бол маш том дүн. Энэ дээр бүр кампанит ажил явах ёстой юм уу? Маш том төлөвлөгөө гарч байгаад олон талаасаа хамжиж байгаад энэ эргэн төлөлт дээр ажиллах ёстой юм биш үү? Энэ дээр сайдад ямар нэгэн төлөвлөгөө биелж байгаа зүйл байна уу? Энийг асууя. Энэ 2 асуултад хариулт авъя.

Ч.Ундрам: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ үнэн үнэн. Энэ үнэхээрийн өмнөх зээлээ төлөөгүйн өмнө дараагийнхаа боломжийг булааж байна л гэсэн үг шүү дээ. Туйлын шударга бус. Суралцах эрхийг нь шууд зөрчиж байна, хөндөж байна гэсэн үг. Тэгэхээр бид энэ программ, мэдээлэл солилцох энэ ажлаа хийгээд бараг дуусаж байгаа. Дууссан биз дээ? Дуусчихсан байгаа. Уучлаарай дуусчихсан. Тэгэхээр энэ боломжтой болсон. Одоо тэгвэл дотор нь ялгаж, салгах л ажил явж байгаа.

Хоёрдугаарт, таны хэлж байгааг бүр бүрэн ойлгож байна. Энэ жил 33 тэрбумыг бид үнэхээрийн буцааж төлүүлж авахгүй бол түрүүн таны хэлсэн үнэн. Энэ олон жилд 14.6 тэрбум л буцаж ирсэн. Тэгээд энэ нөхцөл байдалд бид шуурхай арга хэмжээ авахгүй бол болохгүй.

2, 3 арга зам байна. Тэр эхнийх нь тэр E-Mongolia системээр тэр зээлийн мэдээлэл нь өөр дээр нь шууд очдог юм. Зээлийн мэдээлэл гээд очдог ийм болсон нь сайн тал.

Хоёр дахь нь болохоороо зэрэг бид энэ Монголбанкны мэдээлэлд оруулснаар төлөлтийг сайжруулна.

Гуравт нь прокурорын байгууллагуудад хандана, хандаж байгаа тийм ээ Сийлэгмаа? Хандаад явж байгаа.

Дөрөвт нь болохоороо заавал шүүх, цагдаа гэлцэхгүйгээр асуудлыг шууд хуулийн фирмийг хөлсөлж ажиллуулаад тодорхой хэмжээнд бас хамтран ажиллах ийм бас боломжууд байгаа. Ийм арга замуудыг хэрэглэнэ.

Ер нь энэ зээлийн эргэн төлөлт дээр миний бие ч гэсэн яг маш тантай яг адилхан санаа зовж байна. Энэ эргэн төлөлт байхгүй бол жишээлбэл, Ерөнхийлөгчийн тэтгэлгээр явж байгаа хүүхдүүдтэй сая би Польш, Чехэд очоод л уулзлаа. Үнэхээрийн мундаг хүүхдүүд эндээс явахад нь бас гаргаж өгдөг, ярилцаж үздэг. Тэд бол үнэхээрийн амжилттай суралцаж байна. 98 хувь нь амжилттай сурч байна шүү дээ. Ерөөсөө ийм. Одоо тэд бол ирээдүйн Монголыг авч явах бас шинэ үеийн сэхээтнүүд, шинэ маягийн сэхээтнүүд шүү дээ. Тэгэхээр ийм байж байгаа энэ энд ингээд боломжгүй болчихвол яана гэсэн айдас үнэхээрийн байгаа учраас тантай ч гэсэн хамтарч ажиллая. Энэ эргэн төлөлтийг сайжруулах дээр бид шуурхайлъя. Таны шүүмжлэлийг шууд хүлээж авч байна.

Ч.Ундрам: Ерөнхийдөө гишүүд асуулт асууж, хариултаа авлаа. Асуулга тавьсан Батнайрамдал гишүүн бас үг хэлж, асуулт асуулаа.

Энэ Боловсролын зээлийн сантай холбоотой шүгэл үлээсэн гол 2 хүн энэ танхимд өнөөдөр сууж байна шүү дээ. Хоёулаа тодорхой хэмжээний эрх мэдэл гаргах түвшинд, Батнайрамдал гишүүн Их Хурлын гишүүн болчихсон. Тэгээд танд энэ ажлын хэсгийг ахлуулаад ингээд тодорхой хугацаанд ажиллууллаа. Сийлэгмаа дарга бас шүлэг үлээгээд одоо энэ санг хариуцаад ингээд ажиллаж байна. Тэгэхээр одоо яг энэ мөчид л бид нар маш хурдан, шуурхай ажиллаад ингээд тодорхой шийдвэрүүдийг гаргаад цаашаа явмаар байна.

Гишүүд сая хэлж байна. Монголбанканд яаралтай мэдээллээ өгье. Энийг бол тэр тогтоолын төсөл дээр ч гэсэн бид нар оруулаад, яаралтай мэдээллийг өгье гэдэг дээр гишүүд хэлж байна. Мөн энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах мэргэжил дээр хүмүүс яагаад орж ирэхгүй байна. Энэ дээр бас бид нар мэдээлэл олгогдохгүй байна шүү дээ. Яг ямар ямар мэргэжлээр би Боловсролын зээлийн сангийн зээлд нь ч юм уу, тэтгэлэгт нь хамрагдаж болох юм бэ гэдгийг жирийн иргэдээс та нар гараад асуу. Мэдэхгүй байна. Хаанаас тэр мэдээллийг авах юм? Тэр мэдээллийг бас сайн өгмөөр байна гэх мэтчилэн бид нар нэлээн энэ асуудал дээр бишгүйдээ зөндөө ярилаа. Байнгын хороогоороо энэ асуудлыг хэдэн ч удаа ярив. Одоо сайд та салбар хариуцаж байгаа сайдын хувьд энийг шуурхайлмаар байна. Энэ хүмүүсээ хурдан хурдан уулзуулаад тэр хэрэгтэй шийдвэрүүдийг нь гаргуулаад. Энд чинь ерөөсөө сайжруулъя. Сайжруулахгүй гэсэн 1 ч хүн энэ танхимд алга байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр нь л хурдан засаж залруулаад ингээд явмаар байна.

Үүнээс гадна энэ боловсролын багц хуультай холбоотой жижиг сажиг сайжруулах, засах асуудлууд байгаа. Энийг бас манай гишүүд зарим нь өргөн барих гээд бэлдэж байна. Энэ дээр удахгүй хэлэлцэгдээд ингээд явчих байх. Жишээлбэл, энэ багш нар тасралтгүй 15 жил төрд ажилласан бол 1 хүүхэд нь их сургуульд, улсын их сургуульд сурна гэсэн энэ заалтад тасралтгүй гэдэг үгийг авъя гээд маш олон багш нар санал ирүүлж байгаа. Энэ дээр бид нар бас засаад дунд нь яах вэ хүний амьдрал юм чинь бас жилийн чөлөө авсан ч байдаг юм уу тэрийг бас ойлгох ёстой байх гэж бодож байна. Тэгээд ийм ажлуудаа шуурхайлъя. Энэ шинэ Их Хурал бүрдээд, Засгийн газар бүрдээд бараг жил болох гэж байна шүү дээ. Бид нар ингээд л яриад л, 2 талдаа мэтгэлцээд л суугаад байж болохгүй. Хурдан энэ ажлуудаа шийдээд ингээд явмаар байна.

Батнайрамдал гишүүний асуулгыг бид тэр хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орьё. Миний эрүүл мэндийн байдал нэлээн хүндрээд байгаа учраас хурлыг Дамдинням гишүүн даргалаад үргэлжлүүлээд даргалаад явна.

16.16 цаг

Г.Дамдинням: Дараагийн асуудалдаа орьё.

Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч Батнайрамдал танилцуулна.

Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Байнгын хорооны дарга аа, эрхэм гишүүд ээ

Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 2 дугаар тогтоолоор Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, Г.Дамдинням, Б.Найдлаа, О.Саранчулуун, М.Сарнай, С.Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6, 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу бэлтгэн танилцуулж байна.

Ажлын хэсэг энэ хугацаанд 6 удаагийн хуралдаан зохион байгуулж, Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа болон Боловсролын яамны мэдээллийг сонсон холбогдох асуудлуудыг хэлэлцлээ. Мөн ажлын хэсгийн гишүүд болох Ж.Галбадрах, О.Саранчулуун нар өөрсдийн амжилттай хэрэгжүүлж буй тэтгэлэгт сангийн мэдээллийг өгсөн. Үүнээс гадна ажлын хэсгийн гишүүд Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж судалгаа хийсэн болно.

Ажлын хэсгийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн холбогдох журам ба бусад хөгжиж буй оронд хэрэгжиж буй ижил төстэй журмуудын бодлого, хэрэгжилтийн талаарх харьцуулсан судалгаа, мэдээллийг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээр холбогдох судалгааг хийлгүүлсэн болно.

Түүнчлэн их, дээд сургуулийн оюутан залуучууд болон ЕБС-ийн сурагчид, эцэг эх, асран хамгаалагч зэрэг нийт 9000 гаруй төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг хийж, санал бодлыг нь сонссон болно.

Эдгээр хуралдаан, хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд дараах гол саналуудыг боловсруулан танилцуулж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Боловсролын зээлийн санг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан нийгэм, эдийн засгийн өсөлт, хөгжилд хувь нэмрээ оруулах, өндөр боловсролтой, чадварлаг боловсон хүчин бэлтгэх, олон улсын сайн туршлага нэвтрүүлсэн жишиг сан болгон хөгжүүлэх стратегийг боловсруулан хэрэгжүүлэх.

2.Монгол Улсын Засгийн газраас баталдаг тэргүүлэх эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан шинэчлэн сайжруулж, журамд тусгах.

3.Сургалтын байгууллагад суралцагчид төрөөс дэмжлэг үзүүлэхдээ ил тод, нээлттэй, шударга, ёсыг баримтлах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх болон үндэслэл бүхий байх зарчим баримтлах.

4.Гадаадын сургалтын байгууллагад суралцагч нь сургуулиа төгсөөд эх орондоо эргэж ирэхээс өмнө тухайн олон улсын байгууллагад мэргэжлээрээ тодорхой хугацаанд туршлага хуримтлуулан ажиллахыг дэмжих, нэмэлт гэрээ хийх зэрэг уян хатан зохицуулалтыг тусгах.

5.Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадын сургалтын байгууллагад суралцсан төгсөгчид эх орондоо эргэж ирэх нөхцөл, шаардлагыг эхнээс нь гэрээнд тусгаж, тэтгэлгээр гадаадад сурсан суралцагч нь эх орондоо эргэн ирэхгүй гэрээг зөрчсөн тохиолдолд тэтгэлгийг зээлийн хэлбэрт шилжүүлэх зэрэг эргэн төлөөлөх хариуцлагын оновчтой механизмыг журамд тусгах.

6.Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журмыг 2023 онд шинэчлэн батлагдсан Боловсролын багц хууль болон бусад эрх зүйн актуудтай нийцүүлэн цоо шинээр бүтэц, системийн системчлэл, оновчтой, давхардал, хийдэлгүй, ойлгомжтой байдлаар томъёолон боловсруулж, 2025 оны сонгон шалгаруулалтыг тус шинэчилсэн журмын дагуу зохион байгуулах.

6.1.Журмын нэрийг оновчтой, ойлгомжтой, найруулгын алдаа зүйн алдаа, давхардалгүй, тодорхой болгох.

6.2.Журмын үндсэн хэрэглэгч болох суралцагчдад ойлгомжтой болгох үүднээс тус журмын бүтцийг төрөөс үзүүлж буй дэмжлэгийн төрөл болох зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж гэсэн ангиллаар төрөлжүүлэн оновчтой системчлэх.

6.3.Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журамд зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлт дэмжлэгээр суралцахаар хүсэлт гаргасан этгээдэд тавигдах шаардлагыг төрөл тус бүрд дахин дурдагдсан давхардал, хийдлийг арилган системчлэх.

7.Дэлхийн шилдэг их, дээд сургуулийн сургалтын төлбөрийн дийлэнх хувийг гадаад, дотоодын бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн суралцагчийн үлдсэн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгах.

8.Дэлхийн шилдэг их, дээд сургуулийн зэрэглэл тогтооход олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Таймс Хайер Эдүкэйшн Ворлд Юниверсити Ранкинг/Times Higher Education World University Rankings/ болон Академик Ранкинг Оф, Ворлд Юниверситиэс/Academic Ranking of World Universities/ гэсэн 2 зэрэглэлийг баримталдаг байсныг хоёрдмол агуулгагүй болгож, цаашид ойлгомжтой, оновчтой болгох үүднээс зөвхөн 1 шалгуур Таймс Хайер Эдүкэйшн Ворлд Юниверсити Ранкинг/Times Higher Education World University Rankings/ ашиглах.

9.Гадаадын сургуулиас тавьсан шаардлагыг ханган шалгалтдаа тэнцэж урилга авсан суралцагчаас нэмэлтээр гадаад хэлний шалгалтын оноо, IELTS, TOEFL iBT шаардах зэрэг хүндрэл, чирэгдэл үүсгэдэг зарчмын ач холбогдолгүй шаардлагуудыг хасаж, журмын шалгаруулалтыг оновчтой тодорхойлох.

10.Гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчдын сонгон шалгаруулалтын үйл явцыг шударга бөгөөд аливаа субъектив нөлөөллөөс нөлөөлөлгүй оновчтой хийх үүднээс элссэн сургуулийн эрэмбэ, мөн тухайн

суралцагчид сургуулиас олгосон тэтгэлгийн хэмжээ, сургалтын төлбөрийн нийт хэмжээ зэрэг үзүүлэлтийг үндэслэх.

Тухайлбал, 10.1.Дэлхийн шилдэг их, дээд сургуулийн зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Таймс Хайер Эдүкэйшн Ворлд Университи Ранкинг/Times Higher Education World University Rankings/ байгууллагын сүүлд тогтоосон эрэмбийг үндэслэн нийт онооны тодорхой хувийг.

10.2.Суралцагчид тухайн сургуулиас олгосон тэтгэлгийн хэмжээг үндэслэн нийт онооны тодорхой хувийг.

10.3.Сургалтын төлбөрийн нийт хэмжээнээс хамаарч нийт онооны тодорхой хувийг нийт сургалтын төлбөрийн хэмжээ бага байх тусам оноо өсөх зарчмыг баримтлах.

11.Зээл нь хүүгүй байх, заавал эргэн төлөгдөх, эргэн төлөлтийг орлогын түвшинтэй уялдуулж, хариуцлагын тогтолцоог оновчтой тодорхойлох.

12.Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг хөндлөнгийн хяналттай болгож, сургалтын зээлийн эргэн төлөх үүрэг зөрчигдсэн тохиолдолд шийдвэрлэх механизмыг оновчтой тодорхойлох.

13.Зорилтот бүлэг рүү чиглэсэн буцалтгүй тус боломжийг оновчтой бөгөөд тэгш хүртээмжтэй хуваарилах хүрээнд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй журмын 8.3 дахь заалтад эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу 70 болон түүнээс дээш хувь алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулах заасан хувь хэмжээг 50 хувь буюу түүнээс дээш болгон өөрчлөн найруулах.

14.Дотоод болон гадаад сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчийн зээлийн гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд мэдээллийг ялгаварлалгүйгээр Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлжүүлж, хэрэгжилт болон хариуцлагын тогтолцоог сайжруулах.

15.Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны мэдээллийн санг бүхэлд нь цахимжуулах.

16.Боловсролын зээлийн сангаас олгогдож буй дэмжлэгийн нэр төрөл, хамрах хүрээг тэдгээрт хамрагдах суралцагчдын боловсролын зэрэг эргэн төлөх чадамж болон бусад нөлөөлөх хүчин зүйлүүдтэй уялдуулан оновчтой тодорхойлох.

Тухайлбал, 16.1 гадаадын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах тохиолдолд зөвхөн тэтгэлгийн төрлүүдээс сонгон суралцахыг тусгах.

16.2.Бакалаврын үндсэн хөтөлбөрт тэтгэлгийн суралцагч сургалтын төлбөрийг эргэн төлөх асуудлыг цэгцэлж, төсвийн төлөвлөлттэй уялдуулах.

17.Төрийн албан хаагчдыг чадавхжуулах хүрээнд гадаадын болон дотоодын сургалтын байгууллагад магистр, докторын үндсэн хөтөлбөрт хамруулах. Шаардлагатай тохиолдолд гадаад хэлний бэлтгэлд хамруулах боломжийг олгох.

18.Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 103 дугаар тогтоолоор баталсан багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдүүдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн сайжруулж, багшийн мэргэжлээр цалинтай оюутан хөтөлбөр хэрэгжүүлэх замаар ЕБС-ийн шилдэг төгсөгчдийг орон нутагт багшаар ажиллах бодлогыг дэмжих.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг шинэчлэх нь зөвхөн ил тод, нээлттэй байдлаа хангах төдийгүй шударга, хүртээмжтэй байх зарчмыг дагаж, улс орны хөгжилд чиглэсэн боловсон хүчин бэлдэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Шинэчлэлт нь эргэн төлөлтийн хяналтыг сайжруулж, стратеги бодлоготой уялдуулан боловсролын санхүүжилтийн тогтолцоог илүү үр дүнтэй, зөв менежменттэй болгон хэрэгжүүлэх нь улс, орны нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх тул дээрх бодлогын хэрэг өөрчлөлтүүдийг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны шинэчлэл, сайжруулалтыг тусгасан журмын төслийг боловсруулан 2025 оноос эхлэн мөн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Дамдинням: Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

П.Наранбаяр Боловсролын сайд, Б.Батцэцэг Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батцэцэг гэдэг дарга чинь та шүү дээ. Дуудаад хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар дуудаад 7 хоног олдохгүй юм. Яагаад хариу өгдөггүй юм? Тэрийг дараа нь асууна шүү. Б.Энхбаяр Боловсролын яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, О.Сийлэгмаа Боловсролын зээлийн сангийн захирал.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух дэгтэй. Үг байхгүй. Асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.

Саранчулуун гишүүнээр тасалъя. Гишүүд орохгүй байна уу тээ? Рэгдэл гишүүн оръё, Эрдэнэбат гишүүн бас гарчихсан юм байна тийм үү? Рэгдэл гишүүнээр тасалъя. О. Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Түрүүн цагтай холбоотойгоор асууж амжаагүй 1 асуултаа дахиад тодруулчихъя. Түрүүний ярьсан зүйлээ үргэлжлүүлээд хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч гээд мэргэжилтнүүд байгаа. Одоо протезыг нэмлээ гэхэд энэ хүмүүс байгаа одоо байгаа журмаар мэргэжлээрээ техникийн боловсролын сургалтын байгууллагад ажиллана гэсэн ийм журмаар зохицуулж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хүмүүс чинь яг үнэндээ эмнэлэг, сувилал, сэргээн засах төвүүдэд ажилладаг хүмүүс байхгүй юу. Тэгэхээр энэ журам дээр тэрийг нь тодорхойлж ингэж зохицуулж өгөх бололцоо яг байгаа юу? Хэрвээ байвал бол

одоо энэ сайжруулж байгаа дээр энийг оруулчих боломж юу байна вэ гэдгийг дахиж баталгаажуулж би асуугаад байгаа гэсэн үг.

Түрүүний 70 хувиас 50 хувь гэдгийг сая дурдсан л даа. Гэхдээ би дахин баталгаажуулж асуухад 70 хувь болгох, 50 хувь болгохын хоёрын хооронд хэдий хэмжээний тоо зөрүү байдаг вэ? Энэ дээр та хэд нийгмийн халамжийн журамтай холбоотой 1 асуудлыг бас хөндөж байсан. Энэ хэр ер нь бодитой байна вэ? Одоо энэ зөвлөмж дээр байгаа 70 хувийг 50 хувь болгоно гээд байгаа. Өөрөөр хэлбэл, эцэг эх нь хөдөлмөрийн чадвараа 50 хувиас дээш алдсан байвал ордог болчихмоор байгаа байхгүй юу. Яг үнэндээ бид нар ингэж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дотор нь ангилмаар ч үгүй байгаа юм үнэндээ бол. Дотор нь ингээд л энэ нь илүү хүнд өвдсөн, энэ нь арай хөнгөн өвдсөн ч гэх юм уу, энэ 2 хөлгүй, энэ 1 хөлгүй гэж ангилах яг үнэндээ бас л их л том л ялгаж байгаа хэрэг.

Гэхдээ санхүүгийн нөөц, бололцоогоо хараад 70 хувь гээд зоочхож. Гэтэл 70 хувь ээж, аавынх нь хэн нь 70 хувь хөдөлмөрийн чадвараа алдсан байна гэдэг асар хүнд. Магадгүй тэр айлын хүүхдүүд дээд сургуульд сурах энэ өндөр шалгуурууд давах хэмжээний чадавхтай биш ч байж магадгүй. Орчин нөхцөл нь бүрдээгүй.

Тэгэхээр энэ 70-ыг 50, өшөө ч бараг багасгах ийм бололцоо юу байна вэ? Энэ дээр ер нь тоон ийм тооцоолол байна уу? Тийм хүнд болоод ингээд 70 болгочихсон юм уу гэдгийг дахиж бас тодруулмаар байна.

Г.Дамдинням: Саранчулуун гишүүний асуултад хэн бэ? Ажлын хэсгийн 8 дугаар микрофон Боловсролын зээлийн сангийн захирал Сийлэгмаа.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулъя. Саяын заалт Хөдөлмөр магадлалын комиссоос баталсан 70-аас дээш хувийн санхүүжилттэй гэсэн энэ зохицуулалт нь нийгмийн халамжийн журмаар зохицуулагдаж байгаа. Бид тэр салбарын зохицуулалтыг үндэслэж 70-аас дээш хувийн хөдөлмөрийн чадвар алдалттай өрхийн гишүүний 1 суралцагчийг тэтгэлгээр суралцуулах ийм зохицуулалттай.

Хоёрдугаарт нь түрүүний хэлсэнчлэн зарим эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа иргэд тэтгэлгээр суралцаж төгсөөд орон нутагт 3 жил, нийслэлд 5-аас доошгүй жил хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт, үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тэтгэлгийн гэрээний үүргээ биелүүлсэн гэж үзээд энэ санхүүжилтийг үргэлжлүүлэн хариуцлагын асуудал нь тэгж зохицуулагдсан байгаа. Журам болон гэрээн дээр.

Г.Дамдинням: Саранчулуун гишүүн тодруулах уу? Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Тийм яах вэ яг тэрийг л асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг эмнэлэг энэ мэргэжилтнүүд чинь мэс заслын дараах нийгмийн эрүүл мэндийн хоёрдогч сэргээн засалт болох эмнэлэг, сувилал, сэргээн засах төвүүд ажиллах ёстой учиртай мэргэжлүүд байгаа байхгүй юу сургалтаас. Тэгэхээр энэ журам дээр болохоороо сургалтын байгууллага гээд заачихсан байгаа нь өөрөө магадгүй энэ хүүхдүүдийг тийшээ оруулахгүй байх руу бас нэг юм биш үү гэдэг ийм зарчмын асуудал л юм л даа. Энийг одоо энэ журмаа шинэчилж байхдаа оруулах боломж байна уу л гээд байгаа юм.

Энэ заавал ингээд сургалтын байгууллага гэж тодотгох нь ямар учиртай юм? Энэ чинь багш биш учраас энэ хүмүүс чинь хөдөлгөөн засалч, хэл засалч яг л хүмүүстэйгээ ажилладаг газар. Тэр эмчилгээ хаана байдаг вэ гэхлээр эмнэлэгт байдаг, сувилал, сувиллын газар, сэргээн засах төвүүд байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ журам дээрээ л тэр эмнэлэг, сувилал, сэргээн засах гэж нэмээд өгөхөд хэр болохгүй юу л гэж би асуугаад байгаа байхгүй юу. Тэр халамжийн 70 хувь.../минут дуусав./

Г.Дамдинням: Тийм, энэ Боловсролын хууль хийж байхад яригдаж байсан байхгүй юу даа. Тэр хүүхдүүд чинь хөөрхий амьтан байнгын асаргаа, сувилгаанд байдаг хүүхдүүд чинь энэ Саранчулуун гишүүний хэлээд байгаа яг тэр газрууддаа л байгаа байхгүй юу. Тэгээд тэнд нь очоод хийчхэж болохгүй юм уу л гээд байна шүү дээ тээ?

Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Уучлаарай. Тэгэхээр Саранчулуун гишүүний хэлээд байгаа үнэхээр үндэслэлтэй. Энэ болно шүү дээ. Бид шаардлагатай бол одоо яг яригдаж байгаа энэ журам дээрээ л өөрчлөлтийг нь оруулаад л явуулчихъя. Тэгэхгүй бол, нэг хэсэг мэргэжлийн боловсролын сургуулиудад яг энэ чиглэлийн багш нар ингээд дутагдсан учраас ингэсэн байх магадлалтай.

Харин таны хэлээд байгаа яг энэ хүмүүс чинь үнэхээрийн тийм эмнэлэг дээрээ, яг сэргээн засах төвүүд дээрээ ажиллаад байгаа ийм үед энэ хүн нь хангагдаж л бол бидний зорилго биелж байгаа гэсэн учраас энэ өөрчлөлтийг бид оруулъя. Оруулаад явчих хэрэгтэй. Ойлголоо. Баярлалаа.

Г.Дамдинням: Ажлын хэсгийн ахлагч Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Энэ Саранчулуун гишүүний дэвшүүлж байгаа энэ асуулт ямар ч байсан бид нар 70-аа 50 болгоод сайжруулж байгаа хэлбэр. Гэхдээ бас тоог нь үзэхээр яг Саранчулуун гишүүний үнэ зөв байхгүй юу. 2022, 23, 24 онд нийт хөгжлийн бэрхшээлтэй их, дээд сургуульд суралцаж байгаа сурагчид 404, 414, 436 л байдаг юм байна. Ойролцоогоор 400 орчим хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй байсан. Тэдний яг ямар нэгэн байдлаар Боловсролын зээлийн сангийн хөнгөлөлттэй дэмжлэг, буцалтгүй тусламж, тэтгэлэг авсан хүүхдүүдийн тоо нь жишээлбэл 22 онд 67 л байгаа юм. 404-өөс 67, 2023 онд 414-өөс 28 болоод буурчихсан. Тэгээд 24 онд дахиад бүүр 18 болоод л буурчихсан юм байна лээ л дээ.

Тэгэхээр энэ нийт дүнгээр нь аваад үзэх юм бол энэ чинь Монгол Улсад одоогийн 2024-өөс 25 оны турш 150 мянга гаруй их, дээд сургуульд суралцаж байгаагийн 436 хөгжлийн бэрхшээлтэй иргэд л байгаа байхгүй юу. Суралцагчид орж байгаа. Тэгэхээр тэднийгээ их ялгаварлахгүйгээр энэ болсон.../минут дуусав./

Г.Дамдинням: Тэгээд яах вэ юу яамаар юм байна лээ шүү. Аймгуудад байдаг насан туршийн боловсролын төвүүд байна шүү дээ. Аймаг, дүүргүүдэд байгаа насан туршийн боловсролын төвүүдээр дамжуулаад энэ боловсролын үйлчилгээ авахаар хуульд уг нь зохицуулсан юм байгаа юм. Тэгээд энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг чинь хувьсах зардлыг нь 2 дахин өсгөөд, тэгээд дээрээс нь ерөнхий боловсрол дээр нь.

Дээд боловсрол дээр нь тэр үйлчилгээнүүдийг нь тэр насан туршийн боловсролын төвөөр нь дамжуул дөхчихдөг байдлаар хийе гэдэг ийм л концепцтой явж байсан шүү дээ. Тэр талаас нь бас бодож журам дээр оруулчихвал зүгээр санагдаад байгаа шүү ажлын хэсгийнхэн.

Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Энэ 1.9 дээр би бас өмнө нь санал хэлж байсан. Жоохон найруулгын юм ингээд оруулчихвал зүгээр болов уу гэж бодож байна. Дэлхийн шилдэг их, дээд сургуулиуд гэхээр яг тухайн мэргэжлээрээ тэргүүлдэг сургуулиуд гэж бас байна. Топ 100-д ордоггүй мөртөө яг тухайн мэргэжлээрээ дэлхийд тэргүүлдэг. Ийм нэн хэр эрэлт, хэрэгцээтэй чиглэлээр сурч байгаа хүүхдүүдийн өөрсдөө сургалтынхаа төлбөр тэтгэлгийг олчихсон хүүхдүүд их олон байна.

Гэхдээ зарим хүүхдүүд үлдэж байгаа байр сууцаа өөрөө даадаг, хоол, ундаа өөрөө даадаг иймэрхүү ачааллаас нь хөнгөлөх байдлаар тэр хүүхдүүдийг бас дэмжиж өгөх хэрэгтэй байна. Тэр ч утгаараа энэ заалтыг би оруулсан юм.

Тийм учраас энийг арай тодотгож өгөөд дэлхийн шилдэг их сургуулиуд болон тухайн мэргэжлээрээ, нэн хэрэгцээт мэргэжлээр тэргүүлдэг их, дээд сургуулиудын төлбөрийнхөө дийлэнх хувийг гадаад, дотоодын эх үүсвэрээс бүрдүүлсэн суралцагчийн үлдсэн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх, дэмжлэг, урамшуулал үзүүлэх талаар тусгах гэж байгаа.

Өөрөөр хэлбэл, өөрөө тэтгэлгийнхээ 80 хувийг өөрөө олчихсон. Зарим сургуулиуд өөрийнхөө байрны зардлыг өөрөө даана гээд тавьдаг. Гэхдээ амьжиргааны бас энэ байрны зардал гэх юмыгаа дийлдэггүй тийм хүүхдүүд зөндөө байгаа. Эс үгүй бол 4 жил болоход ирж, буцаж чаддаггүй, гэртээ эргэж ирж чаддаггүй, онгоцныхоо зардлыг дийлдэггүй тийм хүүхдүүд байгаад байдаг байхгүй юу. Тэгээд ийм хүмүүсийг хэрхэн яаж дэмжих юм бэ?

Өөрөөр хэлбэл, өөрөө тэтгэлгээ олоод, сураад ингээд явж байгаа хүүхдүүдийг тодорхой хэмжээгээр дэмжихгүй бол бид нар Боловсролын зээлийн сангаас олж чадсан бүх бараг 100 хувь тэтгэлгээ даалгаад яваад байдаг. Өөрөө хөөцөлдөөд хөөрхий ингээд явж байгаа хүмүүс, зарим хүмүүс байраа тавьдаг, машин тэргээ зардаг, бүх хадгаламж, мөнгө төгрөгөө хоосолдог тийм хүмүүс олон байна. Хүртээмжийг нь нэмэх зорилгоор энэ заалтыг оруулж өгөөч ээ гэсэн хэлсэн.

Дараагийн нэг асуудал нь энэ Боловсролын зээлийн сангаас манай багш нар маань өөрсдөө ерөөсөө бараг сураагүй юм байна лээ шүү дээ. Ер нь ЕБС, СӨБ-ын хүмүүс, мөн их, дээд сургуулиудын багш нарыг бас сургах хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ тэргүүлэх юу чиглэл рүү цаашдаа энэ журмаар тэр тэргүүлэх нэн хэрэгцээтэй гэдэг энэ мэргэжлүүд дээр тодорхой тавьж өгвөл зээлийнхээ бүтцэд бодлогоор тавьж өгвөл хэрэгтэй байна.

Тухайлбал, тэр хөдөө гэхэд малын зоо техникч, мал үржүүлгийн ийм чиглэлээр мэргэшсэн энэ хүүхдүүдийг гадаад, дотоодод сургах асуудал байж байна.

Саяын тэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хэрхэн, яаж сургах вэ гэдгээр тийм чиглэлээр сургах багш нарыг нь дэмжиж өгөх гэдэг ийм чиглэлийн юмнуудыг

бас ингээд оруулж өгвөл хэрэгтэй байгаа юм. Тийм учраас энэ дээр Засгийн газар чиглэл өгч байгаа учраас яг энэ эргээд нийгэмдээ болон илүү их хүртээмжтэй тодорхой энэ салбар мэргэжлүүдийг илүү дэмжиж өгөх, тухайн нийт зээлийн сангийн 30 хувийг энэ жил боловсролын, ЕБС гэдэг юм уу, эс үгүй бол энэ эмнэлэг тодорхой чиглэлийн мэргэжлээр гэдэг юм уу сургана аа гэдэг ийм чиглэлийг тогтоож болно гэдэг ийм.../минут дуусав./

Г.Дамдинням: Эрдэнэбат гишүүн санал хэлчих үү тээ? Эрдэнэбат гишүүн ээ юу шүү, хэдүүлээ энэ Батнайрамдал гишүүний ахалсан ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлт дээр ярьж байгаа.

Тэгэхээр таны санал мэдээж бид хэдүүлээ дараа нь үргэлжлүүлээд энэ санал, дүгнэлт дээр дийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэх үед та болж өгвөл томьёолол дээр нь ажиллачхаарай. Томьёолол дээр нь ажиллаад хэлчихвэл бүүр их амар болчих байх. Таны урд талд төсөл байгаа байх тээ?

Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ манай Батнайрамдал гишүүний ахалсан ажлын хэсэг ер нь их сайн ажилласан гэж бодогдоод байгаа. 6 хуралдсан юм шиг байна. Тэр нь ч яах вэ ер нь их сайн ажилласан. Би сүүлчийн хуралдаан дээр нь бас халти суугаад ер нь Засгийн газраас гарах журмын 70, 80 хувийг нь энэ ажлын хэсэг ер нь хийчихсэн юм байна даа л гэж бодсон л доо. Тэгээд ямар тэрийг бид нар их Байнгын хороодоороо хэлэлцээд яалтай нь биш. Тэгэхээр энэ тогтоолын хэлбэрээр Засгийн газар руу очих юм байна гэж ингэж ойлгож байна. Их сайн ажилласан, хариуцлагатай ажилласан.

Тэгээд энд ер нь тогтоол руу оруулчихмаар зарим юм энэ журам нь ажлын хэсгийн саналд байгаа мөртөө хасагдчихаад байгаа юм. Тэр бакалавраар суралцагчдыг зонхилон тэтгэлэгт хамруулах гэдэг бол надад их зөв санаа санагдаад байгаа юм. Тэрнээс дээш түвшний суралцагчид зээлээ авч суралцдаг. Ер нь гадаад, дотоодод ялгаагүй. Энэ зарчмыг барьж ажиллавал энэ илүү өргөн хүрээтэй үнэхээр бас ирээдүй рүү чиглэсэн хөрөнгө оруулалтын ач холбогдол өндөр байх болов уу гэж бодож байгаа.

Хоёрдугаарт, энэ манай их сургуулиуд, дээд боловсролын сургалтын байгууллагууд нэг л олон улсын тэр зэрэглэл тогтоодог юм руу хамаарах тухай л их яриад байгаа юм. Жишээлбэл, 20-24 онд ямар зорилго тавьж ажилласан гэхдээ зэрэг Ази тивдээ эхний 100-д Монголоос 2 сургууль оруулна л гэж тавьсан. Тэр ч мэдээж бүтээгүй. Тэгэхдээ зэрэг энэ зэрэглэл, тэр ранкингийн асуудал их амин чухал юм шиг болоод явчхаж байгаа. Сая ажлын хэсэг энэ дундаасаа тодорхой системийг нь тэр Таймс Хайер Эдүкэйшн/Times Higher Education/ ч юм уу. Ингэж сонгож аваад үүгээрээ зэрэглэх тухай ярьж байгаа юм.

Миний бодлоор бол манай их сургуулиуд энэ зэрэглэл рүү их мундаг зорилго болгож орж явмааргүй байгаа юм. Сүүлийн үед энэ зэрэглэл тогтоодог энэ системүүдийг чинь гадаад ертөнцөд маш их шүүмжлээд эхэллээ. Одоо аягүй бол энэ зэрэглэл тогтоодог юмнуудыг хүлээн зөвшөөрөхөө удахгүй болимоор болоод яваад байгаа юм. Тэгээд энэ зэрэглэл рүү орох зорилгоо болгоод тавьчихдаг. Миний зүгээр хувийн итгэл үнэмшлээр энэ их, дээд сургуулиуд чинь дээд боловсрол олголтын түвшнээ яаж дээшлүүлэх вэ гэдэг юман дээрээ төвлөрч

ажилламаар. Энэ зээлийн санг, энэ зээл, тусламжийн ажлыг энэ зорилго руу нь бас чиглүүлж ашиглах нь их чухал санагдаад байгаа юм. Би бас зарим сургуулийн Удирдах зөвлөлд гишүүнээр ч, даргаар ч ингээд л бас ажиллаж л байсан. Сургалтын түвшин, дээд боловсрол олголтын түвшнийг сайжруулъя гэдэг асуудлыг ерөөсөө оруулж ирдэггүй шүү дээ сургуулийн удирдах зөвлөл дээр. Багш нарын цалин нэмэх асуудал нэгдүгээрт, хоёрдугаарт энэ аль нэгэн ранк руу хамаарахад юу юу хийх вэ гээд л зохион байгуулалтын юм орж ирээд байгаа.

Тийм учраас энэ зэрэглэлийн асуудлыг бид нар их ач холбогдол өгмөөргүй.../минут дуусав./

Г.Дамдинням: Ажлын хэсгийн ахлагчаас л хариулах байх даа. Ер нь тэр бакалавр болон ахисан түвшний харьцааг ер нь яах юм бэ гэдэг л юм байна шүү дээ. Тэгээд тэтгэлэг байх юм уу, зээл байх юм уу.

Батнайрамдал гишүүн хариулъя.

О.Батнайрамдал: Рэгдэл гуай ямар ч байсан таны асуусан 2 асуулт дээр бас ажлын хэсгийн дүгнэлттэй холбоотойгоор хариулъя.

Бакалаврын түвшинд таны хэлж байгаа бол сая санал, дүгнэлт дээр яг л уншигдсан зүйл л дээ. 16.1 дээр гадаадын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах тохиолдолд тэтгэлгийн төрлүүдээс сонгон суралцахаар гээд.

Тэгэхээр жишээлбэл, өнөөдөр 24 оны гүйцэтгэлийг аваад үзэх юм бол Боловсролын зээлийн сангийн нийт санхүүжилтийн бараг 35 орчим хувь нь Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг. Нэг ёсондоо бакалавр руу явж байгаа хөтөлбөр рүү аль түрүүн явж байгаа. Тийм, явж байгаа. Тэгэхээр тийшээгээ илүү чиглэж явах нь бас зөв гэдэгтэй санал байна.

Хоёрдугаарт нь та эрэмбийн асуудал ярьж байна л даа. Тэгэхээр одоо яг хуучин, одоо явж байгаа хүчин төгөлдөр байгаа сонгон шалгаруулалтаар жишээлбэл үнэлэхдээ нийт оноожуулалтын 80 хувь нь дэлхийн зөвхөн их сургуулиудын эрэмбийг харна гэж байгаа юм. 80 хувь нь эрэмбэ байгаа юм. Энийг бид нар энэ ажлын хэсгийн дүгнэлт дээрээ биш 80 биш, тэрнээс гадна бусад хэлбэрүүдийг авч үзэх хэрэгтэй гэж оруулж ирж байгаа юм. Тухайн оюутны өөрөө тухайн сургуулиас авсан тэтгэлгийн хэмжээ. Дээрээс нь бас тухайн сургуулийн нийт төлбөрийн хэмжээ гэх мэтчилэн бусад факторуудыг авч үзэж, сонгон шалгаруулалтын оноогоо тодорхойлох ёстой.

Тэгэхээр дэлхийн эрэмбэ бол 80 хувь биш, 30 хувь ч юм уу тэр хэлбэр рүү. Яагаад гэхлээр дэлхийн эрэмбэ гэдэг өөрөө хэн нэгэн субъектив нөлөөнөөс хамаарахгүйгээр яг олон улсад ингээд эрэмбэлчихсэн хэлбэр. Тэгэхээр үүгээр хүүхдүүдэд шалгаруулахдаа ашиглах ёстой. Гэхдээ 80 хувь хувь биш, илүү 30 оноо ч юм уу нийт онооны 20, 30 хувь дээр байх нь бас илүү оновчтой болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр яг бид нарын ажлын дүгнэлтэд нэг ёсондоо яг таны хэлж байгаа санаа ингээд суучихсан гэж ойлгож байгаа.

Г.Дамдинням: Надад нэг, би протоколд үлдэх ёстой учраас ажлын хэсгийн хүрээнд бид нар ярьж байсан протоколд үлдэнэ гэдэг утгаараа бас асуулт байгаад

байгаа юм. Хэрлэн гишүүн асуулттай юм байна тээ? Хэрлэн гишүүнийг асуултад оруулчихъя. Хэрлэн гишүүн асуулт асууна. Та ирцдээ орчихсон байгаа юу?

Б.Хэрлэн: Энэ Засгийн газарт өгөх чиглэлийн энэ дээр 1.3-д бичигдсэн байна.

Г.Дамдинням: Хэлэлцэх асуудлын маань өнөөдөр яг ажлын хэсгийн дүгнэлт ярьж байна. Дараачийн асуудал Засгийн газрын тогтоол. Тэр рүүгээ орох уу, одоо эсвэл ярих гэж байна уу? Энэ дүгнэлт дээр нь ярих гээд байна уу? Тогтоол нь дараачийн асуудал.

Б.Хэрлэн: Тогтоолд тусгах санаануудтай холбоотой асуулт асуугаад санал хэлж болох уу?

Г.Дамдинням: Болно шүү дээ. Тийм таны бүрэн эрхийн асуудал.

Б.Хэрлэн: Тэгэхээр энэ дээр яаж байна л даа тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан 1.3-д байгаа юм. Тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгохдоо Засгийн газраас баталсан боловсролын тэргүүлэх чиглэл, эрэлттэй мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээгээр эрэмбэлэн зохицуулалтыг тусгах гэсэн ийм санаа орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр би, бид нар нөгөө энэ хөнгөлөлт авсан хүмүүсийг эргээд хариуцлагатай байлгах үүднээсээ яг энэ тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр сурсан бол төгсөж ирээд яг энэ мэргэжлээрээ ажилласан байх ёстой гэдэг санааг тусгаж өгөх юм бол энэ хүмүүст хөнгөлөлт үзүүлсний хэрэг гарах гээд байна л даа.

Хэрвээ ингэж сурч ирчхээд өөр чиглэл рүү орох юм бол тэр төлбөрөө, одоо 5 жил ажиллалаа гэхэд чинь хөнгөлөгдөх, чөлөөлөгдөх тийм асуудал байх уу, үгүй юү гэдгийг ялгавартайгаар гаргаж ирэхгүй бол сайхан хэлтэй хүн, том сургууль төгссөн хүн өөр салбарт өөр ажил хийгээд явчих юм бол улс оронд хэрэггүй болчихно л доо. Тэгэхээр энэ талын зохицуулалтыг оруулж өгөөч.

Тэгээд 1 удаа хөнгөлөлт авсан бол 2 дахь удаад нь бас тийм хөнгөлөлт, зээл ч юм уу, тэтгэлэг ч юм уу байх уу, үгүй юү гэдэг тухай асуудал бас орж ирэх хэрэгтэй юм шиг байгаа юм. Магадгүй 1 удаа зээл, тэтгэлэг авчхаад дараагийн удаад нь зээл аваад явчхаж бас болзошгүй шүү дээ. Тэгэхээр тооных нь хувьд хязгаарлах тухай. Сураад ирсэн яг ажил мэргэжлээрээ ажиллах улс орондоо хувь нэмрээ оруулах тухай асуудлыг бас энэ дээр хариуцлагажуулж оруулж өгмөөр байгаад байгаа юм. Ийм санаа байна.

Г.Дамдинням: Хэрлэн гишүүн дараагийн асуудалтай холбогдуулаад л асуучихлаа. Тэгэхдээ яах вэ зүгээр ажлын хэсгийн ахлагч Батнайрамдал гишүүн энэ ажлын хэсэг дээр энэ тухай асуудлууд яригдаж байсан эсэх талаар нь хариулчихвал болох байх тээ?

Ажлын хэсгийн ахлагч Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Ажлын хэсгийн хуралдаан дээр Хэрлэн гишүүний тавьсан асуултууд ер нь яригдсан. Одоо ч гэсэн явж байгаа журмаар тухайн хүүхэд тэргүүлэх, эрэлтэй мэргэжлээр жишээлбэл зээл авчхаад, тэтгэлэг авчхаад буцаад яг тухайн мэргэжлээрээ жишээлбэл, дотоодын зээл дээр орон нутагт 3 жил, илүү хот суурин газар 5 жил ажиллаж байж тэр нь буцаад гүйцэтгэх шалгуураа хангана

гэсэн зохицуулалтууд явдаг байгаа. Тийм. Тэгэхээр тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр тэтгэлэг, зээлийн хэлбэр авч байгаа бол буцаад яг тэрүүгээрээ эх орондоо тодорхой хугацаанд ажиллаж байж үүрэг нь бас биелнэ гэсэн зохицуулалтууд байгаа юм. Тийм.

Г.Дамдинням: Хэрлэн гишүүн тодруулах юм уу болчихсон уу?

Ажлын хэсгийн ахлагч, манай ажлын хэсгийнхэн яамныханд зүгээр асуулт шүү, би протоколд оруулах гээд байгаа юм байна. Ажлын хэсэг дээр ч гэсэн бид нар яриад л байсан. Энэ ажлын хэсгийн дүгнэлтийн 7, 8 байгаад байгаа юм. 7 дугаар заалт болох дээр зэрэг гадаад, дотоодын бусад эх үүсвэрээс сургалтын төлбөрийн тодорхой хувийг бүрдүүлсэн Монгол Улсын иргэний үлдэгдэл төлбөрийг шийдвэрлэлт зохицуулалтыг тодорхой тусгах гэж.

Тэгэхээр энэ дээр тодорхой хэмжээний шалгуур тавих тухай асуудал бид нар ярих ёстой байх тээ? Ийм асуудлыг бид нар ажлын хэсэг дээр ярьж байгаа, ярьсан байгаа байх.

Хоёрдугаарт, энд түрүүн энэ Эрдэнэбат гишүүний яриад байсан тэр зөвхөн сургалтын төлбөр гэлтгүй амьжиргааны зардал дээр нь бас өгдөг барьдаг тухай асуудлыг ер нь та ярилцсан уу, ярилцаж байгаа биз дээ? Би тэр талаар нь яг микрофон дээр авчихмаар байгаа юм 7 дээр.

8 дугаар асуудалд, 8 дугаар заалт байгаа юм ажлын хэсгийн дүгнэлтийн. Дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтооход олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Таймс Хайер Эдүкэйшн Ворлд Университи Ранкинг/Times Higher Education World University Rankings/ болон Академик Ранкинг Оф, Ворлд Университиэс/Academic Ranking of World Universities/ гэсэн 2 зэрэглэлийг баримталалдаг байсныг хоёрдмол агуулгагүй болгож цаашид ойлгомжтой, оновчтой болгох үүднээс зөвхөн 1 шалгуур Таймс Хайер Эдүкэйшн Ворлд Университи Ранкинг/Times Higher Education World University Rankings/-ийг ашиглах гээд оруулчхаж байгаа байхгүй юу. Би энэ дээр ийм эргэлзээ төрчхөөд байгаа юм. Магадгүй энэ чинь тив тивээсээ хамаараад 3 үнэлгээний систем л яваад байгаа байхгүй юу. Азиуд 1 үнэлгээтэй, Европууд 1 үнэлгээтэй, хойд Америк дундаа 1 үнэлгээтэй. Яах вэ тэгээд л эхний 50, 100 дотроо байдаг.

Тэгэхдээ дээр доороо ороод яваад байдаг байхгүй юу. Тэнд чинь ранкинг ингээд явахтай зэрэг магадгүй энэ дээр ийм хувилбар байж болоогүй юу? Яагаад гэвэл бид нар ганцхан үнэлгээний системд шууд сонгоод ингээд явчихаар бас эргэлзээтэй болчих байх. Ази руу сургуульд явах гээд байгаа хүүхдийг Азийн үнэлдэг үнэлгээгээр нь Европ руу явдаг хүүхдийг Европын үнэлгээгээр нь, хойд Америк руу явах гээд байгаа хүүхдийг хойд Америкийнх нь үнэлгээгээр нь ингэж үнэлээд явдаг зарчим руу хийх тухай асуудал ер нь яригдсан уу? Яагаад энийг бид нар ярихгүй байгаа вэ гэдэг асуудал дээр 3 тодруулга авчихъя.

Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Та 7, 8 дугаар асуудал ярьж байна тээ? Дэлхийн шилдэг их сургуулиудын сургалтын төлбөрийн дийлэнх хувь нь, хэрвээ ямар нэгэн өөрийн эх үүсвэрээс гадаадаас байна уу, эсвэл тухайн сургуулиасаа тэр хүүхэд ямар нэгэн тэтгэлэг, дэмжлэг авчихсан бол нөгөө талаасаа илүү төр бас тэн дээр нь дэмжих, дэмжих хэлбэр байж болно гээд 7 дугаар заалт дээр оруулж байгаа юм.

Тогтоол дээр орж байгаа учраас энийг илүү зарчмын хүрээнд ерөнхий тусгаж өгсөн байгаа. Журам дээрээ яам ажиллахдаа энэ дээр илүү нарийвчилсан, ойлгомжтой зохицуулалт орж ирэх ёстой.

Гэхдээ бас анхаарах ёстой зүйл сонгон шалгаруулалтаар бүх юм заавал явах ёстой. Тэр хүүхэд жишээлбэл хэчнээн тэтгэлэг тухайн авсан ч гэсэн заавал сонгон шалгаруулалтаар, нэгдсэн сонгон шалгаруулалтдаа орж явах зохицуулалт дотроо л тусаж явах ёстой гэж байгаа юм л даа.

Дээрээс нь дэлхийн шилдэг их, дээд сургууль гэж оруулсан л байгаа л даа. Тэгэхдээ энэ дээрээ бас ажлын хэсгийн хүрээнд бас нэлээн ярилцсан. Та бүхэн бас өөр санал байх юм бол энэ дээр бас ярилцъя. Нэгэдүгээрт.

Хоёрдугаарт, эрэмбийн хувьд энэ 2 эрэмбэ бол сүүлийн бараг 10 хэдэн жил Боловсролын зээлийн сангийн журамд байсаар ирсэн юм байна лээ.

Таймс Хайер Эдүкэйшн Ранкинг/Times Higher Education Rankings/ бол ер нь жишээлбэл, манай МУИС яг энэ эрэмбэ рүү дөнгөж түрүү жилээс анх орж ирсэн ер нь дэлхийн бараг 4, 5 мянган их сургууль эрэмбэлэгддэг ийм ерөнхий эрэмбэ байгаа.

Академик Ранкинг Оф, Ворлд Юниверситиэс/Academic Ranking of World Universities/ гэдэг болохоор илүү докторын түвшинд ресерч бэйсед юниверсити/research based universities/ гэж ярьдаг судалгаан дээр суурилсан докторын жишээлбэл хэдэн Нобелийн шагнал багш нь авсан ч гэх юм уу илүү судалгаа руу чиглэсэн зүйлүүдийг нэлээн тусгаж өгдөг, илүү докторын жишээлбэл түвшинд эрэмбэ илүү хамааралтай байж болох ийм эрэмбэ байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ерөнхий түвшиндээ ийм 2 үзэмжээр явж хоёрдмол утга гаргаж байснаас одоо явж байсан хамгийн оновчтой тэрийг нь л ашиглачихвал болох болов уу гэсэн санаа.

Тэгээд таны хэлсэн жишээлбэл, тив тив дээр илүү ондоо эрэмбэтэй тэрийг бас бид нар ярилцсан тээ. Ингээд харахаар бас дахиад аягүй олон бас эрэмбэтэй, олон эх сурвалжтай л болох гээд байхаар илүү хялбархан, сонгон шалгаруулж байгаа ажлын комисстой ямар нэгэн субъектив нөлөөлөл орохгүйгээр л ойлгомжтой болох үүднээс л 1 эрэмбийг нь тогтсон гэсэн санаа явж байгаа.

Г.Дамдинням: Яаман дээр ер нь энэ чиглэлээр хийсэн судалгаа юмнууд байдаг юм уу, харьцуулаад ер нь олон улсын түвшинд энэ бусад улс орнууд ер нь ранкингийг яаж ашиглаж тэтгэлэг хийдэг юм байдаг юм уу Наранбаяр сайд аа?

Наранбаяр сайд хариулъя. Ажлын хэсгийн 8.

П.Наранбаяр: Ер нь энэ эрэмбийн чансааг ингэж тогтоох энэ манайх бол Таймс Хайер Эдүкэйшн/Times Higher Education/-г л ашиглаж байгаа. Тэрнээс л юм авдаг. Үнэхээрийн Рэгдэл гишүүний хэлсэнчлэн шүүмжлэлүүд гараад байгаа юм сүүлийн жилүүдэд яг ингээд жагсааж болоод байгаа юм уу, тухайн тухайн орон нутагтаа хувь нэмрээ оруулдаг өөрийн онцлог бүхий их сургуулиуд байгаа шүү дээ гээд. Энийг бол хүлээн зөвшөөрнө. Гэхдээ нэгэнт бид бас энэ эрэмбэ, энэ чансааг ингэж тогтоодог болно гээд ингээд хуулийн заалттай. Үүнийхээ дагуу журам нь ч гарчихсан ингээд явж байгаа. Цаашдаа бас бид бас судалж үзье. Чухам алиныг нь ашигладаг юм.

Жишээлбэл, Таймс Хайер Эдүкэйшн/Times Higher Education/-нийг ашиглахгүй, ашигладаггүй орнууд ч бас байдаг. Өөрсдийн гэсэн бас юутай ингээд явдаг. Байдаг л юм байна лээ. Тэрийг цааш нь судалж үзье.

Г.Дамдинням: Тийм, журам боловсруулахдаа та хэд маань яг энэ 3 том үнэлгээний л юм яваад байгаа. Тэгэхээр эндээс нь ер нь харж байгаад ер нь бид нартай ер нь ойролцоо шийдлүүд хийж байгаа, тэтгэлэг өгч байгаа улс орнууд ер нь яаж ашиглаад байна. Тэр дээр нь энэ Их Хурлын гишүүд, бид нарт, энэ Байнгын хорооны гишүүдэд мэдээлэл өгөөдхөөч. Тэгэхгүй би бас ганцхан үнэлгээ дээр шууд очоод суурилчихвал жоохон эргэлзээтэй юм даа гэдэг бодол байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бас энийгээ харцгаана биз дээ. Магадгүй Кюү Эс-ийн үнэлгээгээр 100-д орж байгаа сургууль Таймс/Times/-ынх дээр 120-д орчхож байгаа байхгүй юу. Нөгөөдөх нь адилхан л дэлхийн их сургууль 100 дотор байгаад байдаг, тэтгэлэг авчихмаар байдаг, Монгол Улсад хэрэгцээтэй мэргэжилтэн байгаад байдаг. Тэгэхээр чинь бас хүмүүс гомдох л байхгүй юу. Магадгүй бид нар ардчилсан улс учраас сонголт аль болох иргэддээ өгдөг энэ чиглэл рүү нь харж хийвэл ер нь зөв болов уу л гэсэн байр суурьтай асуугаад байгаа юм.

Боловсролын зээлийн санхүүгийн үйл ажиллагаа журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэж бас гишүүд асуулт асууж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

16.54 цаг

Байнгын хорооны тогтоолын төсөл. “Засгийн газарт чиглэл өгөх тухай”.

Ажлын хэсгийн гаргасан ажлын хэсгээс гаргасан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол,

2025 оны дугаар сарын өдөр, Улаанбаатар хот, “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооноос тогтоох нь:

1.Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэд даалгасгай.

1.1.Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд олон улсын сайн туршлага, жишээг нэвтрүүлэх арга хэмжээг авч, урт хугацаанд тогтвортой мөрдөгдөх зохицуулалтыг тусгах.

1.2.Суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгохдоо ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, үндэслэл бүхий байх зарчмыг баримтлах.

1.3.Тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгохдоо Засгийн газраас баталсан боловсролын тэргүүлэх чиглэл, эрэлттэй мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг эрэмбэлсэн зохицуултыг тусгах.

1.4.Зорилтот бүлэгт чиглэсэн буцалтгүй тусламжийг оновчтой бөгөөд тэгш хүртээмжтэй хуваарилах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх.

1.5.Гадаадын сургалтын байгууллагад суралцагчдыг сургуулиа төгсөж эх орондоо ирэхээс өмнө мэргэжлээрээ тухайн орон, олон улсад туршлага хуримтлуулах зорилгоор тодорхой хугацаанд ажиллахыг дэмжсэн уян хатан зохицуулалтыг бий болгох.

1.6.Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадын сургалтын байгууллагад суралцсан төгсөгчдийг эх орондоо ирэх нөхцөл, шаардлагыг тодорхойлж, тэднээс гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын оновчтой механизмыг бүрдүүлэх.

1.7.Журмыг боловсруулахдаа Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох эрх зүйн актуудад нийцүүлэх, бүтэц, системчлэл оновчтой, давхардал, хийдэлгүй, ойлгомжтойгоор томъёолж батлах.

1.8.Суралцагчийг сонгон шалгаруулахдаа аливаа нөлөөлөл, ашиг сонирхлоос ангид байгаа, элсэн суралцах сургуулийн эрэмбэ, сургалтын төлбөрийн хэмжээ, суралцагчийн авсан тэтгэлгийн хувь, хэмжээ зэрэг үзүүлэлтийг нарийвчлан тусгах.

1.9.Дэлхийн шилдэг их сургуулиудын сургалтын төлбөрийн дийлэнх хувийг гадаад, дотоодын бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн суралцагчийн үлдсэн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгах.

1.10.Зээлийн эргэн төлөлтийн нөхцөл, журмыг тодорхой болгох, хөндлөнгийн хяналтын механизмыг бий болгон нэвтрүүлэх, үүргээ зөрчсөн, хариуцлага алдсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхой заах.

1.11.Боловсролын зээлийн сангийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, ажлын хүрээнд зээлийн эргэн төлөлтийг сайжруулах.

1.12.Дотоод болон гадаадын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагч зээлийн гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд мэдээллийг ялгаварлалгүйгээр Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлжүүлэх, хэрэгжилт болон хариуцлагын тогтолцоог сайжруулах.

1.13 Засгийн газраас 2024 оны 103 тоот тогтоолоор баталсан багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй

мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсронгуй болгох.

2.Энэ тогтоолын биелэлтийг намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газрын Л.Оюун-Эрдэнэд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрамд даалгасугай.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Ажлын хэсгээс гарсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулттай гишүүд байвал нэрсээ өгье.

Болчихсон уу?

Саранчулуун гишүүнээр тасалъя. Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Энэ гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгохыг эргэн төлүүлэх, тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журмыг боловсронгуй болгох талаар Засгийн газарт чиглэл өгөх тогтоол гарах нь зүйтэй юм аа гэж ингэж бодож байна. Тэгээд энэ тогтоолын заалттай холбогдуулаад 2 жижигхэн асуулт байна.

Нэгдүгээрт, энэ 1.5 байгаа юм. Тэгэхээр 1.5 дээр гадаадын сургалтын байгууллага суралцагчдыг сургуулиа төгсөж эх орондоо ирэхээсээ өмнө гадаадаа ажиллах тухай байгаа юм л даа. Тэгэхээр энэ сургуулиа төгсөхөөсөө өмнө ажиллах тухай юм уу, төгссөн хойноо ажиллах тухай яриад байна уу 1.5 чинь? Төгсөхөөсөө өмнө ажиллах бол сурч байхдаа мэргэжлээрээ ажиллана гэдэг жаахан ойлгомжгүй. Төгссөнөөсөө хойно ажиллана гэвэл сургуулиа төгсчхөөд тэнд мэргэжлээрээ ажиллахыг дэмжсэн зохицуулалтыг энд оруулъя гээд байна шүү дээ тийм ээ? Тэгэхээр энийг тодорхой энэ томъёолол жаахан ойлгомжгүй байх шиг байна.

Хоёрдугаарт, энэ 1.9 дээр энэ төлбөрийн дийлэнхийг бүрдүүлсэн суралцагчдын төлбөрийн асуудал байгаа юм. Тэгэхээр дийлэнх гэдэг нь яг жаахан ойлгомжгүй. 50-аас хувиас дээшийг хэлэх гээд байна уу, эсвэл 99 хувиа хэлэх үү? Энийг яаж тодорхой болгож болох вэ гэдэг ийм асуудал байна.

Энэ 1.12 дахь заалт байгаа юм. Бас Монголбанкны мэдээллийн систем гээд түрүүн бас нэлээн яригдчихсан. Энийг заавал л Байнгын хорооны тогтоолд оруулах шаардлага байна уу, үгүй юү гэдэг ийм л 3 асуулт байх шив дээ.

Г.Дамдинням: Ажлын хэсгийн ахлагч Батнайрамдал гишүүн хариулъя.

О.Батнайрамдал: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. 1.5 дээр жоохон уншигдахдаа тэгсэн юм болов уу. Нэг ёсондоо гадаадын сургалтын байгууллагад гадаадад сурч байгаа оюутан төгсөөд эх орондоо эргэж ирэхээс өмнө нэг ёсондоо

сургуулиа дуусчхаад тухайн орондоо жишээлбэл яг мэргэжлээрээ Японд жишээлбэл Токиогийн их сургуульд сурч байгаад компьютерын шинжлэх ухаанаар сурч байгаад тэнд “Амазон” компанид ажилд орчих юм бол тэндээ 3 хүртэл тодорхой хугацаанд яг заана л даа мэргэжлээрээ ажиллаж байгаад ирэх юм бол илүү мэргэжилтэй, туршлагатай боловсон хүчин болж ирнэ гэсэн. Энэ дээр надад олон хүүхдүүдийн хүсэлт ирсэн юм л даа. Тэгэхээр олон хүүхдүүд, ойлголоо. Тийм нэг ёсондоо төгсөөд. Яг үнэн төгсөөд гэх юм бол илүү ойлгомжтой. Төгсөөд мэргэжлээрээ 3 хүртэл жил ажиллаад эх орондоо ирэх боломжийг нь олгох ёстой гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь 12-ыг нь эхлээд тайлбарлачихъя. Энэ Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлжүүлье. Энэ асуудал хүртэл ингээд шийдэгдэхгүй яваад байгаа учраас энийг тогтоолын төсөл дээр заавал оруулах ёстой л гэж бодож байгаа юм. Одоо хүртэл яагаад шийдэгдэхгүй байгаа юм? Бид нар энийг шийдээрэй гээд жил ярьсан шүү дээ. Тэгэхээр яг энэ өрөөнд Монголбанкны Дэд ерөнхийлөгч хүртэл бид нар бэлэн байна аа гээд ярьж байсан. Одоо хүртэл шийдэгдэхгүй. Тийм учраас тогтоолын төсөл бүгдээрээ энийг заавал оруулах ёстой л гэсэн байр суурьтай байгаа юм.

1.9 дээр та бас тодорхой асуулт асууж байна л даа. Дийлэнх хувь гэхээр тодорхой бус байна гээд. Тэгэхээр энийг би шинэчлэн найруулах нь зөв гэж бас бодож байна. Тэн дээр та бас тодорхой саналаа байвал бас хэлээрэй.

Г.Дамдинням: Рэгдэл гишүүн тодруулах уу, болсон уу?

Энэ 1.9 дээр ажлын хэсгийн дарга аа, Наранбаяр сайд аа энэ 1.9 дээр энэ уг нь дэлхийн шилдэг их сургуульд Монгол Улсад нэн хэрэгцээтэй мэргэжлээр элсээд орчихсон хүнийг Ерөнхийлөгчийн тэтгэлгээр ч гэдэг юм уу, ийм тэтгэлгүүдээр ингээд 100 хувь даачхаад тэтгэлэг авчихсан хүнийг нь болохоор зэрэг тодорхой хэсгийг нь, дийлэнхийг нь гээд жоохон шахчих дэмий л харагдаад байгаа юм л даа. Зүгээр тодорхой хэсгийг нь л гээд оруулчихвал уг нь зүгээр санагдаад байгаа байхгүй юу. Тийм боломж уг нь баймаар л байгаа юм даа. Наранбаяр сайд юу гэж бодож байна энэ дээр та? Ажлын хэсгийн 8.

П.Наранбаяр: Одоо бол 50 хувь хүртэл олдсон хүнийг олгоод явж байгаа шүү дээ. Тэгээд 50 хувиа өөрөө олоод ирвэл үлдсэн талыг нь төрөөс даах энэ зээл хэлбэрээр шийдэх энэ юм явж байгаа. Энэ жоохон хатуураад дийлэнх гэсэн байна. Дийлэнх олонх гэвэл 75 хувь л гэж би ойлгодог. Хуучин заалтаар явж байхад асуудалгүй шүү дээ. Тийм зүгээр өөрөөр хэлбэл 50-аас эхлээд л бодчиход болно. Яагаад гэвэл гадаадынх чинь их тийм өндөр төлбөртэй байдаг. Тэгээд буцаж ирээд эх орондоо ажиллаад төлнө гэх юм бас их хэцүү тал байдаг. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор өмнөх заалт бас орж ирж байгаа болов уу гэж бодсон. Гадаадаа 3 жил ажиллаад тодорхой хугацаанд ажиллаад гээд. Бас хүн туршлагажаад ирж болно. Дээр нь нэмээд төлбөрийн чадвар арай сайтай ийм цалин аваад ирэхээрээ эргэн төлөлт сайжрах магадлалтай.

Гэхдээ нэг талдаа эргэж ирэх яг тэр үүргийг нь маш сайн тодорхой бас яахгүй бол тархины урсгал гадагшаа болчих вий л гэж бас айдас байгаа. Баярлалаа.

Г.Дамдинням: Асуулт бол тодорхой хэмжээнд хариулагдлаа. Миний асуугаад байгаа нь энэ байхгүй юу. Тодруулж асуугаад байгаа юм сайд аа

Ерөнхийлөгчийн тэтгэлэг гээд л энэ бусад тэтгэлгүүд байгаа шүү дээ эд нар дээр чинь бид нар тэнцчихсэн бол шууд 100 хувь өгчхөж байгаа шүү дээ. Тэгээд тэтгэлэг олчихсон хүүхдүүдийг 5 хувь, 10 хувь, 30 хувь, 40 хувийн тэтгэлэг авчихсан байгаа хүүхдүүд дээр яагаад үлдсэнийг нь бүтэн өгчхөж болохгүй байгаа юм бэ л гээд байна шүү дээ. Ялгаагүй байхгүй юу тэд нар шилдэгт л элсчхээд байгаа юм чинь. Энийг бодоцгоогоорой. Тэгээд хэдүүлээ томьёолол дээр нь ажиллачихвал зүгээр юм шиг байна.

Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Тогтоолын төслийн 1.3 дээр тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан суралцагчдад гээд ингээд байж байгаа юм. Тэгэнгүүтээ энэ дээр ингэж байгаа байхгүй юу Засгийн газраас баталсан боловсролын тэргүүлэх чиглэл гээд тусдаа 1 чиглэл гарах нь гэж би ойлгож байна. Одоо манай 14 төсөл дээр ажиллах боловсон хүчин ч гэдэг юм уу. Энэ 1 тусдаа бичиг гарна гэж би тэгж ойлгож байна. Зөв үү гэдгийг асууя.

Хоёрт нь дахиад эрэлттэй мэргэжил гэж байгаа юм. Эрэлттэй мэргэжил гэдэгт миний яриад байгаа протез чинь, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч маань орох билүү? Энэ чинь тусдаа дахиад ийм жагсаалт байх уу гэдгийг асуух гээд байгаа юм. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ гэдэг энэ эрэмбэ энэ 3 янзын ойлголт байна уу гээд асууж байгаа юм. Ингээд явж байнгуут 1.9 рүү харахаар дэлхийн шилдэг их сургуулиуд гээд дахиад ороод ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 4 янзын ийм тодорхойлолттой юм болохоор жишээлэх юм бол юу гэдэг юм Завхан аймагт амьдардаг би 12 дугаар анги төгсөж байгаа би миний орсон сургууль маань өөрөө энэ Засгийн газрын чиглэл үү, эрэлттэй мэргэжил үү, эсвэл дэлхийн шилдэг үү гэдгийг нь харахын тулд аль хэсэгт нь орох вэ гэдэг энэ жоохон ийм толгой эргүүлсэн юм шиг болоод байна л даа. Энэ чинь яг үнэндээ хүүхэд нь тэтгэлэгт орж байгаа эцэг, эхчүүд янз бүрийн хүмүүс энийг уншина шүү дээ. Тэгэхээр энэ ангиллын нэлээн сайн цэгцэлмээр л санагдаад байна. Нэг олгомоор юм уу гэж бодогдож байна ажлын хэсэгт.

Бас нэг юм нь би дахиад асуух гээд байгаа юм. 2 дахь удаагаа суралцах гэдэг юм энэ дээр ер нь яригдаад л байгаа. Тэгэхдээ тэр 2 дахь удаагаа суралцах гэдэг дээр миний хэлээд байгаа санаа болохоор эмзэг бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах мэргэжилтнүүд буюу эцэг эхчүүд өөрсдөө нэг болохоор эцэг эхчүүд өөрсдөө хөгжлийн бэрхшээлтэй биш шүү дээ. Хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй байхгүй юу. Тэгэхдээ тэр хүмүүс өмнө нь өөр мэргэжилтэй сурч байгаад амьдралын янз бүрийн асуудлаар юу гэдэг юм хүнтэй гэрлээд суусан чинь хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй төрчихжээ, одоо би энэ хүүхдээ нэгэнт асрах юм байна насан туршдаа. Тэгэхээр би энэ чиглэлээр суръя гээд ингээд сонгож байгаа хүмүүс чинь тэтгэлгийн зорилтот бүлэг болох оюутан нас нь өнгөрчхөөд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хүмүүст тэтгэлэг өгдөг энэ боломж ер нь нээгдэх үү? Би асуугаад байгаа юм л даа та давхар. Тэгэхээр энийг би энэ 1.4-төө хамааруулж ойлгож болох уу? Энэ өгүүлбэрийн доор энэ байх уу, үгүй юу гэдгийг асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр манайхан энэ дээр би тоо харахаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэдэг тоо тусдаа байна. Харин эцэг, эх нь хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд хүүхэд нь сурсан тоо гэдэг нь дахиад тусдаа баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг сайн хармаар байгаад байгаа.

Нөгөө талд болохоор хэл засалч, хөдөлгөөн засалч нь хүн ирэхгүй байгаа шүү дээ. Гэхдээ хэрвээ ээж, аавууд нь 2 дахь удаагаа суралцах боломж олгочих юм бол суралцъя гэсэн ээжүүд байгаа. Одоо сурч байгаа ээж, аавууд бас байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг мөр болгоод энэ шийдвэл яасан юм бэ гэсэн асуулт байна.

Г.Дамдинням: Наранбаяр сайд хариулах уу? Ажлын хэсгийн 8.

П.Наранбаяр: Энэ сая тэр эрэлттэй, тэргүүлэх хөдөлмөрийн зах зээл 1.3 дээр зах зээлийн эрэлт, хэрэгцээ гэсэн ийм эрэмбэлэлтийн зүйлийн тухайд энэ тэргүүлэх гэдэг нь эрэлттэй 2-ыг Засгийн газрын тогтоолоор шинэчилдэг 5 жил тутамд. Энэ жил бол шинэчлэх жил нь болж байгаа. Тэргүүлэх гэдэг нь Засгийн газрын зүгээс тухайн жишээлбэл энэ 14 мега төсөлтэй холбоотой, яг үүнтэй хамаарах ийм салбарууд гэсэн ийм байдлаар ойлгож болно.

Эрэлттэй гэдэг нь зах зээлийн тэр эрэлтийг бас зааж хэлээд байгаа юм. Энэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээний энэ эрэмбэлсэн энэ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ингээд гаргаж байдаг ийм зүйлүүд бий.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхчүүд энэ өөрсдөө мэргэжлээ сольж суралцсан тохиолдолд дэмжлэг өгөх үү гэдэг асуудлыг ярьж байна. Тэгэхээр энэ одоогийн байдлаар би бас ингээд тоогоо тодруулаад асуухад 29 эцэг, эх суралцсан байгаа юм байна. Тэгэхээр энэ тохиолдолд зээлийн сангаас биш, одоо тийм журам байхгүй учраас яамны зүгээс дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна.

Тэр өөрөө хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч, эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн 1 суралцагч эд нар гээд ийм тоонууд манай яаман дээр бий. Танд энийг 24 оны байдлаар жишээлбэл өөрөө хөгжлийн бэрхшээлтэй 548 суралцагч сурч байна. Эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй 548, гэр бүлийн аль гишүүн нь хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан нь энэ чиглэлээр ингээд зээлд дэмжлэг аваад сурч байгаа ийм оюутны тоо 2123 байна. Тэгэхээр зэрэг энэ чиглэлийн мэдээнүүд нь байж байгаа гэсэн үг.

Г.Дамдинням: Тодруулах уу та? Саранчулуун гишүүн тодруулъя. Тэрний өмнө ийм юм байгаа. Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Хамгийн гол нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй биш ээж аав нь, хүүхэдтэй ээж, аавуудын хувьд 1 асуудал байгаад байгаа. Нөгөө талд ээж, аав нь хөгжлийн бэрхшээлтэй байх юм бол бас 1 асуудал яригдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр би энэ хэл засалч, хөдөлгөөн засалч гэдэг дээр чинь хүн ирэхгүй байгаад байна аа гэдэг чинь энэ бэрхшээлтэй хүмүүстэй ажиллахаар сонгосон, мэргэжлээ сонгож байгаа хүмүүс 18-тай, 19-тэй хүүхдүүд биш байгаад байна. Ээж, аав нар өөрөө бас сурах гээд байна л гээд байгаа. Тэгэхээр тэр ээж, аав нар 2 дахь мэргэжлээрээ сурч байгаа юм уу, эсвэл тэтгэлэг авах нас нь 18, 9 гэдэг нас давсан жишээлбэл 30, 40 настай ээж, аав байж болно шүү дээ. Тэгэхдээ би 2 дахь мэргэжлээ суръя. Тэгэхдээ миний сурах гэж байгаа мэргэжил нь өөрөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах энэ протез байдаг юм уу, хиймэл хөл байдаг юм уу, хэл засалч, хөдөлгөөн засалч болох гээд байгаа үед дэмжих үү л гэдэг асуудлыг асуугаад байгаа байхгүй юу. Энэ бололцоо байх.../минут дуусав./

Г.Дамдинням: Хоёр л юм хэлмээр л санагдаад байна даа.

Нэгдүгээрт юу байгаад байгаа юм Саранчулуун гишүүн ээ. Энэ тэргүүлэх, тэгээд эрэлттэй мэргэжил энэ тэр гээд энэ дандаа Боловсролын ерөнхий хуультай холбоотой асуудлууд байгаад байгаа учраас Боловсролын ерөнхий хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиудтай холбоотой асуудлууд байгаа учраас хэдүүлээ энэ тогтоолын төслийн энэ 1 дүгээр хэсэг дээрээ тэр хуулийнхаа заалтуудыг дурдаад явчихмаар юм шиг байна. Тэгвэл илүү тодорхой болоод Саранчулуун гишүүний яриад байгаа юмнууд тодорхой болчих байх. Тэгж болох байх тээ манайхан? Нэг.

Хоёрдугаарт, нь юуны асуудал байгаад байгаа юм. Энэ Саранчулуун гишүүний энэ яриад байгаа тэр тэргүүлэх, эрэлттэй мэргэжил гэдэгт эд нар хасагдчих вий дээ, тэгвэл орж чадахгүй шүү дээ гэдэг асуудал яриад байгаа учраас энийг нь энэ тогтоолдоо заалт болгоод оруулчихъя л даа. Одоо угаасаа ингэе Саранчулуун гишүүн ээ хэдүүлээ дэгийн тухай хуулиараа асуулт асууж, хариултаа авч дуусчихаад үг хэлнэ. Үг хэлэхдээ хэдүүлээ зүйл, заалт болгон дээр нь санал хураагаад явчихъя. Ингэж томъёолоо гээд. Тэгэхээр түрүүн Эрдэнэбат гишүүн ярьж байсан, Саранчулуун гишүүн ярьж байсан, одоо бас асуулт асуух энэ юутай байгаа гишүүд томъёоллоо бичээд санал хураалгачихъя тэгэх үү? Тэгээд нэмье гэдэг зарчмын саналаа хийгээд ингээд явчихвал арай амар болох байх.

Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Түрүүнийхээ саналаа ерөнхийдөө томъёоллыг нь яачихлаа. Тэгэхдээ энэ 1.9 миний түрүүний хэлдэг санал 2 янзын юм байгаа шүү.

Нэгдүгээрт, дэлхийн шилдэг их, дээд сургуулиуд гэж байгаа.

Хоёрдугаарт, Монгол Улсад эрэлттэй, тэргүүлэх гэдэг юм уу тэр заалтаар нь мэргэжлээр их, дээд сургуулиудад сурч байгаа гэдэг байдлаар нь ойлгож байна. Тэгэхээр гадаад, дотоод ер нь ялгаа байхгүй.

Энэ дээр би нэг зүйлийг Боловсролын яамнаас асуумаар байна. Ерөнхийдөө их, дээд сургуулиудыг ранклахаас гадна тухайн мэргэжлээр ранкладаг тийм юмыг та нар авч үздэг үү яг тухайн мэргэжлээр? Тухайлбал, хөдөө мал аж ахуйн селекцийн чиглэлээр, зоо техникийн чиглэлээр дэлхий дээр энэ манай Монгол Улсын байгаль, цаг уур, бэлчээрийн мал аж ахуйтай хамгийн ойрхон практик дадлага яадаг ч юм уу, Канад ч юм уу тийм сургуулиуд нь илүү байдаг юм аа, бид нар магадгүй тэр Өмнөд Азиудад бэлддэг ч юм уу, Өмнөд Америкт бэлддэг ранк өндөр боловчиг яг манай Монгол Улсын нөхцөл, мал аж ахуй, газар тариалантай арай өөр энэ тэр гэдэг ийм байдлаар нь тухайн мэргэжлээрээ Монгол Улсад л ер нь явж явж хэрэгцээтэй хүмүүсийг сургах гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нар энэ чиглэлээр Боловсролын яамнаас судалсан юу байдаг юм уу? Яг тухайн мэргэжлээр нь ерөнхийдөө Монгол Улсад хамгийн их таардаг, хэрэгцээтэй, Монгол Улсын ирэх 20 жилийн мега төслүүд дээр ажиллахад ийм ийм бид нар компаниудтай хамтарч ажиллана, ийм гадаадын эх үүсвэрийг нь ингээд татах учраас тэр чиглэлийн улс орнуудын их, дээд сургуулиудын төгссөн мэргэжилтэн байвал илүү их манайд хэрэгцээтэй, илүү их нийцтэй байна гэдэг ийм төлөвлөгөө гаргана. Үүнийг тухайн үед нь Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яам яриад нэн тэргүүлэх эрэлттэй гэдгийг нь уян хатан тавьж өгөхгүй бол одоо бид нар тодорхойлох боломжгүй.

Г.Дамдинням: Боловсролын яам, ажлын хэсгийн 8 Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ 2011 онд 2 жил яг таны хэлсэн яг энэ системээр тухайн үед эрэлттэй ийм мэргэжлээ бас ингэж мэргэжлээр нь ранкинг хийсэн, үүнийг ашиглаж байсан ийм түүх бий. Хүүхэд болгонд, бас суралцагч болгонд нь илүү боломж олгох ийм зорилгоор ашиглаж байгаа. Эрэмбэ нь бол Таймс, Хайер, Эдүкэйшн, Кюү Эс, Ранкинг гэсэн энэ хоёрыг л ашиглаж, энэ 2 дээр л шилдэг эхний 50-д орсон сургууль гэдэг ийм байдлаар явуулж байгаа. Тийм.

Г.Дамдинням: Тэгэхдээ энэ Эрдэнэбат гишүүний яриад байгаа аягүй чухал шүү яг үнэндээ. Колорадогийн Голдены уул уурхайн сургууль байгаа байхгүй юу. Дэлхийн хамгийн мундаг баяжуулагчид тэнд бэлтгэгдэж байгаа. Тэр жишээ нь энэ ранкт байхгүй шүү дээ. Тэр номер 1 байхгүй юу тэр чиглэлээр. Эсвэл юу гэдэг юм яг ийм төрөлжсөн их сургуулиуд гээд л бид нар яриад байдаг шүү дээ энийг ийм оруулдаг юмыг хэдүүлээ бас энэ журамдаа хиймээр юм байна даа. Тогтоол дээрээ бас ингээд яг тооцчихмоор юм биш үү тээ? Тэгээд их сургуулиа бүтэн институцээр нь үнэлдэг, бас мэргэжлээр нь үнэлдэг тэр юмыг харгалзаж үзээрэй гэдэг утгаар нь хийвэл уг нь зөв л санагдаж байна шүү.

Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Түрүүний ярьдаг малчны хүүхдийг мал аж ахуйтай холбоотой мэргэжлээр сургуульд үнэ төлбөргүй байх, эх үүсвэр нь Боловсролын зээлийн сан дээр байгаа гэж ойлголоо.

Тэгэхээр энэ яг журам нь гарсан юм уу? Хэрвээ журам нь гараагүй бол энэ тогтоолд оруулж өгвөл яадаг юм бэ? Энэ чинь тэгээд 9 сарын 1-нд бас энэ хүүхдүүд хүрээд ирдэг бас журам нь гараагүй гээд ингээд хойшлоод унах юм болох вий. Журам нь гарсан юм болов уу сайд?

Г.Дамдинням: Хэнээс вэ? Наранбаяр сайд, 8 дугаар микрофон.

П.Наранбаяр: Хосбаяр гишүүний тавиад байгаа энэ асуудал туссан байгаа. Энэ журмаа бид ингээд шинэчлээд батлахдаа энийг энэ эх үүсвэр нь тавигдаад ингээд болно. Гэхдээ бас энэ тогтоолдоо бас оруулаад өгвөл бас сайн байна. Баярлалаа.

Г.Дамдинням: Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Тэгвэл энэ тогтоол дээр 1.14 болгоод ч юм уу энийг оруулж өгөхгүй бол энэ яг энэ жилээс 9 сарын 1-нээс авхуулаад хэрэгжих гээд байдаг хуулийн хэрэгжилт нь. Гэтэл журам нь гараагүй болохоор бас болохгүй байх. Тэгэхээр энийг журам оруулж өгсөн нь дээр байх энэ тогтоолд.

Г.Дамдинням: Оруулсан нь дээр байх. Тэгвэл Хосбаяр гишүүн, тэгээд л Эрдэнэбат гишүүн, манай Саранчулуун гишүүд одоо хэдүүлээ дэгийн хуулиараа хэдүүлээ асуулт асуугаад дуусчихлаа. Одоо үг хэлнэ. Үг хэлэхдээ хэдүүлээ

саналын томъёоллоо шууд томъёолоод, санал хураалгах саналаа гаргаад гаргаад явчих. Тэгээд дарааллаар нь хэдүүлээ хураагаад хураагаад явчихъя тэгэх үү?

Гишүүд асуулт асууж дууслаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Үг, санал хоёроо нэг болгочихъё.

Хосбаяр гишүүнээр тастъя. Эрдэнэбат гишүүн үг хэлье.

С.Эрдэнэбат: Түрүүнийхээ томъёоллыг ерөнхийдөө бичлээ.

1.9 шүү. Дэлхийн шилдэг их сургуулиуд болон Монгол Улсад эрэлттэй мэргэжлээр тэргүүлэх их, дээд сургуулиудад гадаад, дотоодын болон өөрийн эх үүсвэрээс бүрдүүлсэн, тодорхой хувийг бүрдүүлсэн, дийлэнх биш тодорхой хувийг бүрдүүлсэн үлдсэн төлбөр болон амьжиргааны бусад зардалд зохих сонгон шалгаруулалтын үүднээс тэтгэмж, зээлийн дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг тусгах.

Бас зээл авах сонирхолтой хүмүүс байгаа байхгүй юу.

Г.Дамдинням: Эрдэнэбат гишүүн та хугацаа байгаа юм чинь дахиад унш даа.

С.Эрдэнэбат: Дэлхийн шилдэг их, дээд сургуулиуд болон Монгол Улсад эрэлттэй мэргэжлээр тэргүүлэх их, дээд сургуулиудад гадаад, дотоодын болон өөрийн эх үүсвэрээс бүрдүүлсэн, тодорхой хувийг бүрдүүлснээс гадна үлдсэн төлбөр, амьжиргаа болон бусад зардалд зохих сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хэмжээний тэтгэмж, зээлийг дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг тусгах.

Г.Дамдинням: Юу л юм шиг байна шүү дээ. 1.3 дээр байгаад байгаа шүү дээ. Тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгохдоо Засгийн газраас баталсан боловсролын тэргүүлэх чиглэл, эрэлттэй мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээгээр эрэмбэлсэн зохицуулалтыг тусгах гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр юу явал яадаг юм Эрдэнэбат гишүүн ээ, 1.9 дээрээ хэдүүлээ дэлхийн шилдэг их сургуулиудын сургалтын төлбөрийн тодорхой хувийг гадаад, дотоодын бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн суралцагчийн үлдсэн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгах гээд л тодорхой хувийг гээд томъёолоод явчихвал болох уу?

Наранбаяр сайд аа энэ дээр ер нь болох юм уу? Эрдэнэбат гишүүний асуугаад байгаагаар ингээд байна шүү дээ дэлхийн шилдэг их сургуулиудын сургалтын төлбөр, сургалтын төлбөрийн тодорхой хувийг, мөн амьжиргааны зардлын тодорхой хувийг гадаад, дотоодын бусад эх үүсвэрүүдээс бүрдүүлсэн суралцагчийн үлдсэн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгах гээд асуугаад байна.

Ажлын хэсгийн 8.

П.Наранбаяр: Энэ манай энэ чинь зээл нь их ер нь л сургалтын төлбөр рүү нь л чиглэж байгаа. Амьжиргааны зардал гээд би бүх зүйлүүд ороод ирвэл дараа нь хүн дээр очих өөрийнх нь зээлийн дарамт нь ихэснэ. Бидний олгох зээлийн чинь эх үүсвэр нь хүрэхээ болино. Ийм эрсдэл өндөр байна. Энийг та бүхэнд хэлэхээс, ний нуугүй л ярья л даа. Тэгээд энэ жил 33 тэрбум төгрөгийг эргүүлж төлж, эргүүлж та бүхэн төлүүлж ав гэсэн байгаа юм. Эх үүсвэр дээр би яг Батнайрамдал гишүүнтэй адилхан маш их санаа зовж байна. Тэгээд ийм үед ингээд амьжиргааны зардал гээд оруулаад, татаад оруулаад ирэх юм бол бид эх үүсвэрээ татаж чадахгүй, дийлэхгүйд хүрэх болов уу гэсэн айдас байна.

Г.Дамдинням: Одоо ч дэг алга л даа. Хэдүүлээ энд хоорондоо ярьж байгаад л яая л даа.

Эрдэнэбат гишүүн ээ ингэвэл, та 2 санал гаргаж байгаа маягаар явчихвал болохгүй юу? Тэгэхгүй бол яагаад байна л даа. Төлбөрийн тодорхой хувийг гадаад, дотоодын бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн суралцагчийн асуудлыг амьжиргааны зардалтай нийлүүлэхээр гишүүд дэмжихгүй санал уначихвал хоёулаа байхгүй болчих гээд байгаа байхгүй юу. Тийм. 2 санал гаргалаа гэж ойлгоё тээ? Наранбаяр сайдаас дахиад тодруулчихъя даа. Тэгэхгүй энэ дэгээрээ яахгүй микрофон дээр би л ярихаас өөр гарцгүй болчихоод байна.

П.Наранбаяр: Энэ Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 8.3 дээр Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох сургалтын төлбөрийн зээл гэж ингээд тодорхой заачихсан. Тэгээд тэр зээл дотор нь байр эд нар нь орчихсон явж байгаа. Тэрнээс яг энэ амьжиргааны зардал гэдэг юм байхгүй байгаад байгаа ийм тал байгаа шүү. Тийм, тийм ийм нэг юу байна хуулийн.

Г.Дамдинням: Наадах чинь тэгэхдээ Засгийн газрын журам биз дээ?

П.Наранбаяр: Тусгай сангийн хуулийн.

Г.Дамдинням: Тусгай сангийн хууль биз дээ?

П.Наранбаяр: Боловсролын зээлийн сан 8 дугаар зүйл дээр заасан тэрний 8.3 дээр байдаг.

Г.Дамдинням: Хуультай юм байна даа. Хуультай юм байна. Тэгвэл тэгээд Эрдэнэбат гишүүнээ яая даа сургалтын төлбөрийн дийлэнх биш, тодорхой хувийг гэдэг томъёоллоор явчихъя гээд л явчихъя тэгэх үү?

За, шууд. Энэ Эрдэнэбат гишүүний гаргасан тогтоолын төслийн 1.9 дээр дэлхийн шилдэг их сургуулиудын сургалтын төлбөрийн тодорхой хувийг гадаад, дотоодын бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн суралцагчийн үлдсэн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгах гэсэн томъёоллоор өөрчилье гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

81.8 хувиар санал дэмжигдлээ.

Дараачийн гишүүн. Ундрам гишүүнийг дэмжсэнд тооцъё протоколд тэмдэглэхээрэй.

Дараачийн гишүүн үг хэлье. Дэлгэцээ өгөөрэй. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Саналаа томъёолох гэж үзлээ л дээ. Өмнөх нь ихэвчлэн тогтоолд орчихсон учраас хэл засалч, хөдөлгөөн засалч, протезын техникч, хөдөлмөр засалч зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажилладаг Монгол Улсад нэн дутагдалтай байгаа мэргэжилтнүүдийг бэлтгэхэд дэмжиж, төгсөөд мэргэжлээрээ боловсролын байгууллагаас гадна сургалтын эмнэлэг, сувилал, сэргээн засах төв зэрэг газар ажиллуулах зорилгоор 2 дахь удаагаа суралцагчийг дэмжиж болно гэсэн гэсэн ийм заалт байна. Ойлгомжтой байна уу?

Г.Дамдинням: Болно биз дээ тээ? Саранчулуун гишүүний гаргасан томъёоллыг манай ажлын хэсгийнхэн найруулга тал дээр нь ажиллаад тэгээд агуулгынх нь хувьд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

81.8 хувиар санал дэмжигдлээ.

Хэрлэн гишүүнийг дэмжсэнээр авъя.

Хосбаяр гишүүн санал хэлье.

Г.Хосбаяр: Малчны тухай хууль 1 сарын 1-нээс хэрэгжээд эхэлчихсэн байгаа. Тэгэхээр энэ хууль дотор байгаа тэр малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны 1 хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах журмыг боловсруулах гээд 1.14 дээр оруулах ийм саналтай байна. Санал хураалгаж өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Хосбаярын гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо гишүүдийн гаргасан санал болон ажлын хэсгийн хэлэлцүүлгийн үед гарсан саналуудыг тусгах, найруулга зүйн хувьд ажиллаж, эцэслэх байдлаар тогтоолын төслийг бүхэлд нь дэмжиж байна гэсэн, баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дуусах дөхөж байна. Түрүүн бас гишүүд юм ярьж байна лээ. Би хэлэлцэх асуудлуудад ороогүй байгаа учраас төгсгөлд нь хэлчихье гэж бодоод бас үгээ хойш нь татаад сууж байлаа.

Боловсролын сайдад түрүүн Аубакир гишүүн болон бусад гишүүдийн хэлээд байгаа, Сайнзориг гишүүдийн хэлээд байгаа, бас бусад гишүүдээс сонсогдоод байгаа энэ боловсролын салбарыг улс төржүүлэхгүй байх чиглэлд анхаармаар байна. Их олон юм сонсогдож байна. Их, дээд сургуулиудад таны зөвлөх гэж нэртэй нөхдүүд очиж ТУЗ-ийн даргаар нь томилогдоод томилгоонд нь оролцоод үгүй бол ажлаас чинь хална гэж их, дээд сургуулийн захирлуудыг айлгадаг ийм байдал руу орсон байна. Энийгээ тат.

Хоёрдугаарт, Боловсролын ерөнхий хуулиар бид нар ерөнхий зарчим яриад байгаа байхгүй юу. Улс төрөөс ангид байлгая, томилгоог улс төрөөс ангид байлгая гэж дээд боловсролын салбарыг тусад нь гаргасан. Улс төрөөс ангид, боловсрол хямралд орчихсон байгаа учраас энийг өөд нь татаж гаргая гээд босоо томилгоо руу оруулсан. Боловсролын сайд Боловсролын ерөнхий газрын даргыг томилоод, Боловсролын ерөнхий газрын дарга нь орон нутгийн Боловсролын газрын дарга нарыг томилоод ингээд явдаг. Энэ систем рүү орсон.

Боловсролын газрын дарга нар нь сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нарыг томилдог ийм ажил руу орсон. Нэртэй устай гомдлууд ирээд байгаа шүү. Магадгүй та өөрөө тийм бодлого хэрэгжүүлээгүй байж магадгүй. Гэхдээ нэгдлийн улаан бухууд их байна шүү. Энэ асуудал дээр ер нь анхаараарай. Намын батлах өгөөд элсэхгүй бол чамайг ажлаас чинь хална гэдэг асуудлууд яригдаж байна, сонсогдож байна, тойргуудаас ирж байна. Хэмжээнээс хэтэрсэн учраас яригдаж байгаа юм. Энийгээ нэгдүгээрт анхаар.

Хоёрдугаар асуудал, Боловсролын яаман дээр явж байгаа худалдан авах ажиллагаанууд жишээлээд хэлье дижитал боловсролыг бид нар Боловсролын ерөнхий хуулиар оруулсан цахим боловсролыг. Энийг ХҮН намаас нэр дэвшсэн хүн хууль зөрчиж орж ирээд системийг аваад ингээд ажиллуулаад, тулгалт хийгээд хүүхдүүдийн хоолны мөнгөнөөс аваад явчихсан байсан нь илчлэгдээд хэл ам болж байгаа засагдаад явж байгаа ийм мэдээллүүд ирж байна. Хүмүүс ажил хийгээд явж байгаа байх. Мэдээж хууль ёсны дагуу явуулах гэж хичээж л байгаа байлгүй дээ.

Тэгэхээр энэ яам ХҮН намын хүний нөөцийн яам биш, ХҮН намыг санхүүжүүлдэг яам биш. Дээрээс нь хууль бус тушаал гаргаад боловсролыг хагас бие даасан боловсролын тогтолцоонд санхүүжилтийн тогтолцоо руу шилжүүлэе гэдэг хуулийг бид нар хийсэн 2023 онд энэ Ундром гишүүн тэргүүтэй бид бүхэн. Ерөнхий боловсролын сургуулиудаас 120 гаруй сургуулиудаас 10, 10 сая төгрөг өөрсдийнх нь хүсэл сонирхлын эсрэг татаж 1.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд ашиг сонирхол нэгтэй этгээдийнхээ ТББ руу шилжүүлээд хөтөлбөр хэрэгжүүлээд яваад байгаа тухай асуудал яригдаж байгаа. Манай нэр бүхий тодорхой Улсын Их Хурлын гишүүд энэ дээр бас асуудал ярьж орж ирээд байгаа. Тэгэхээр гэх мэтчилэн энэ ашиг сонирхол шингэсэн юмнуудаа ер нь тат.

Тэгэхээр энэ чиглэлээр хэрвээ асуудал хүндэрвэл Улсын Их Хурал энэ дээр дуугүй суугаад байхгүй шүү. Энэ дээрээ бас анхаарна биз. Тэгээд энэ тодруулга авах гээд дуудахаар ирж өгөхгүй байгаа Хөрөнгө оруулалтын газрын дарга тэргүүтэй энэ газрын дарга нарыгаа бас энэ төрийн албанд Монгол Улсын Их Хурал үйл ажиллагаагаа явуулахад мэдээлэл авах гээд дуудахад утсаа ч авдаггүй, хариу ч өгдөггүй алга болдог энэ байдлаа таслан зогсоо гэж бас сайдын хувьд хэлмээр байна наад өөрийнхөө удирдлагад байгаа хүмүүстээ. Мэдээлэл авмаар байна. Зэрэг асуудлуудыг бас анхаарна биз.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа.

17.31 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

